	ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ	АШБ-ТБХ-09-2015
		Хувилбар-1

**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНД БАЙРЛАХ
“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
(ТӨСЛИЙН БАЙРШИЛ, НЭР)**

**2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР 2546191/

2024 он



1. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“ДЦС-3” ТӨХК-ийн үйлдвэрийн хүчин чадал, үйл ажиллагааны чиглэл, бүтэц зохион байгуулалтын талаарх мэдээллийг товч оруулсан болно.

Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч-“Дулааны гуравдугаар цахилгаан станц” Төрийн өмчит хувьцаат компани

Тусгай зөвшөөрөл-Дулаан, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хангах, түгээх, худалдах

Хүчин чадал

1966 оны 12-р сарын 3-ны өдөр Дулааны 3-р цахилгаан станцын суурь тавигдаж, 1968 оны 12-р сарын 10-нд анхны зуух ашиглалтад орж, нийслэл хотын албан байгууллага, орон сууцанд дулааны эрчим хүч түгээж эхэлжээ. Өнөөдрийн байдлаар уг станцын суурилагдсан хүчин чадал цахилгаанаар 198 МВт, дулаанаар 585 Гкал байна.

Үндсэн үйл ажиллагаа

Тус цахилгаан станц дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:


1. Цахилгаан үйлдвэрлэх
2. Цахилгаан түгээх
3. Дулаан үйлдвэрлэх
4. Дулаан түгээх
5. Цахилгаанаар зохицуулалттай хангах
6. Дулаанаар зохицуулалттай хангах

Ажиллах горим, ажилчдын тоо

Станц нь 1001 ажилтнаас Удирдлага -1 ИТА 228, ажилчид 772, үүнээс 230 эмэгтэй ажилтантай, Боловсролын хувьд дээд боловсролтой 383, тусгай дунд 97, бүрэн дунд 434 ажиллаж байна. Үйлдвэр нь өдрийн болон ашиглалтын 4 ээлжийн зохион байгуулалтаар ажилладаг. Тоног төхөөрөмжийн 24 цагийн тасралтгүй үйл ажиллагааг зуны улиралд ашиглалтын нэг ээлжинд 110-130 хүн, өвөл ашиглалтын нэг ээлжинд 140-145 хүн тус тус ажилладаг.

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжийн тухай мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр	“Дулааны III Цахилгаан Станц” ТӨХК
Улсын бүртгэлийн дугаар	9012001004
Регистрийн дугаар	2546191
Улсад бүртгүүлсэн	2005.10.20
Үйл ажиллагааны чиглэл	Дулаан, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хангах, түгээх, худалдах
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, ДЦС-3 ТӨХК байр

	ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ	АШБ-ТБХ-09-2015
		Хувилбар-1

Утас	(+976) 11-343024, 341901
Факс	(+976) 11-343024
Вэбсайт	http://tes3.energy.mn/

Төслийн байршил:

Дулааны III цахилгаан станц” ТӨХК нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт 85 га талбайг хамран байрлана. Тус үйлдвэрийн харьяанд алслагдсан үнс хадгалах сан болон техникийн усан хангамжийн насос станц мөн түүнчлэн ахуй үйлчилгээний, инженерийн, хими цех, лаборатори туршилтын төв зэрэг барилга байгууламж багтдаг.



Зураг-2 “ДЦС 3” ТӨХК-ийн ерөнхий харагдах байдал

Монгол Улсын эрчим хүчний системд нийлүүлж буй бүтээгдэхүүний хувь хэмжээ:

Монгол улсын төвийн эрчим цахилгаан эрчим хүчний хэрэглээний 16.1 хувь, Улаанбаатар хотын дулаан хангамжийн 31.4 хувь, үйлдвэрийн технологийн уурын хэрэглээний 47.5 хувийг хангадаг улсын онц чухал объект юм.

Цахилгаан эрчим хүч:

Станц нь технологийн хэрэглээний усыг Сонсголонгийн гүүрний баруун талд байрлах өөрийн эзэмшлийн худгуудаас татан авч ашигладаг, станцын дулаан цахилгааны эрчим хүч үйлдвэрлэхэд шаардлагатай нүүрсийг дан ганц Багануурын уурхайгаас хүлээн авч хэрэглэдэг. Дунд болон өндөр даралтын зуухнуудад хэт ханасан уурыг боловсруулан, турбингенераторт өгч, цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэн 35/110




киловольтын цахилгаан дамжуулах шугамаар төвийн эрчим хүчний систем ба 6 киловольтын шугамаар хэрэглэгчдэд нийлүүлж байна.

Дулааны эрчим хүч: Ус, уураар

Дулаацуулгын улиралд Улаанбаатар хотын дулаан хангамжийн системийн 31% 7000-8500 тн усыг халаан өгч байна. Мөн хүнс, ноос ноолуур, арьс шир, барилгын материалын 82 үйлдвэр, аж ахуйн нэгж газруудыг технологийн уураар ханган ажиллаж байна.

Улаанбаатар хотын дулаан хангамжийн схем, ачаалал:



Зураг-1 Улаанбаатар хотын дулаан хангамжийн ерөнхий схем

Үйлдвэрийн технологийн уурын хэрэглэгчид:2024 он

№	Хэрэглэгчийн нэр	№	Хэрэглэгчийн нэр
1	"Агар тайж" ХХК	42	"Мон хими" ХХК
2	"Ай Ви Ко" ХХК	43	"Мон энзим" ХХК
3	"Алтай гацуурт" ХХК	44	"Монгол дээвэр" ХХК
4	"Алтайн Харгиа" ХХК	45	"Монгол нэхмэл" ХХК
5	"Алтан эвт холдинг" ХХК	46	"Монгол технологи инвестмент" ХХК
6	"АПУ" ХК	47	"Монгол шевро" ХХК
7	"АПУ" ХК - Спиртийн үйлдвэр	48	"Мон ирээдүй" ХХК



8	"АПУ" ХК - Пивоны үйлдвэр	49	"Монфрэш сүү" ХХК
9	"АПУ Дэйри" ХХК	50	"Наран золбоот кашмир" ХХК
10	"Атар өргөө" ХК	51	"Натур өргөө" ХХК
11	"АТТА ЧР" ХХК	52	"ОБ Пластик" ХХК
12	"А Үйлс" ХХК	53	"Оргил хүнс" ХХК
13	"Бауплюс" ХХК	54	"Пирамид индастри" ХХК
14	"Баянгонгор" ХХК	55	"Прогласс констракшн" ХХК
15	"Би Ай Ви" ХХК	56	"Прост" ХХК
16	"Би Ти Өү" ХХК	57	"Пэк солюшн" ХХК
17	"Би Цэ трейд" ХХК	58	"Сан индустриал" ХХК
18	"Буурал гол" ХХК	59	"Смарт крафт" ХХК
19	"Бэлон" ХХК	60	"Сопрема" ХХК
20	"Витафит инвест" ХХК	61	"Сор" ХК
21	"Ганбармат" ХХК	62	"Суурь" ХК
22	"Говь" ХК	63	"Ти Эс Ар Ананд" ХХК
23	"Говь" ХК - Гоёо үйлдвэр	64	"Ти Эс Жи" ХХК
24	"Денимон" ХХК	65	"ТНГРИ инвест" ХХК
25	"Довцог өндөр" ХХК	66	"Түмэн шир групп" ХХК
26	"Дулаан хөөс" ХХК	67	"УБ барилга" ХХК
27	"Жем интернэшнл" ХХК	68	"УБ хивс" ХК
28	"Жи Эн Бевережис" ХХК	69	"Урбан бизнес групп" ХХК
29	"Жи Эс Эф" ХХК	70	"Хаалга цонх" ХХК
30	"Залуу хүнс" ХХК	71	"Хөнгөн бетон" ХХК
31	ЗХ-ний 011-р анги	72	"Хөнгөн тавцан" ХХК
32	"Их асар" ХХК	73	"Эвтэй намсрай" ХХК
33	"Их эргэлт" ХХК - 1	74	"Экопак монгол" ХХК
34	"Их эргэлт" ХХК - 2	75	"Элит фур" ХХК




**“ДЦС-3” ТӨХК-ИЙН ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЭЛЭЛИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024.10.31

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлт
	1	2	3	4
Агаарын чанар				
1	Станцын үндсэн үйл ажиллагаанаас зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх зохион байгуулалтын хүрээнд нүүрс хадгалалт, тээвэрлэлт, бутлуур цех, конвейер, зуухны яндан, тээврийн хэрэглэлийн хөдөлгөөн, үнсэн сан, зам харгуй, ахуйн хог хаягдлын цэг зэргээс агаар дахь тоосжилт, PM, CO, SO ₂ , NO ₂ ихсэж орчны хүчилтөрөгчийн (O ₂) хэмжээ багасаж болно.	Дулааны цахилгаан станцын үйл ажиллагаанд ашиглагдах утааны яндангаас гарах агаар бохирдуулагчдад тогтмол хэмжилт хийх замаар хяналт тавих, зөвшөөрсөн норм хэмжээнээс хэтэрсэн тохиолдлуудад дүгнэлт хийж шалтгааныг тогтоох, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх	Дулааны цахилгаан станцын үйл ажиллагааны үед	Станцын яндангаар хаягдах утааны хийд MNS 5919:2008 стандартын хүрээнд хяналт тавьж ажилласан. Стандартаас хэтэрсэн үзүүлэлт гараагүй. Суурин болон зөөврийн хэмжих хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмол хийж байна.
2		Үнсэн сангийн тоосжилтыг бууруулах арга хэмжээг төлөвлөх	Үнсэн сангуудыг хамруулах	Үнс хадгалах сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж усан толио үүсгэж тоосролт үүсгэхгүй ажилласан.
3		Гадаад орчны тоосжилтыг дарах зорилгоор усалгааг тогтмол хийж байх	Дулааны улиралд	Станцын талбайд зүлэгжүүлэлт, усалгааг тогтмол хийж ажилласан.
4		Хог хаягдлыг төслийн талбайн орчимд цуглуулалгүйгээр төвлөрсөн хогийн цэгт зайлуулах	Ахуйн хатуу хог хаягдлын орчимд	ХУД-н тохижилт үйлчилгээний газартай гэрээ байгуулан төвлөрсөн цэгт зайлуулж ажилласан. Тус гэрээнд ямар нэгэн зөрчил маргаан гараагүй бол сунгагдах заалттай.
5		Бохирдол ихтэй газар ажиллаж буй ажилчдад хувийн хамгаалах хэрэглэлийг тараах, тогтмол хангаж хэвшүүлэх	Дотоод хяналтын хэлтэс, холбогдох цех нэгжүүд зохион байгуулах	Станцын нийт ажилтнуудад сар бүр хамгаалах хэрэгсэл олгож хувийн хамгаалах хэрэгслийг ашиглаж байна.
		Станцын хэмжээнд ашиглагдаж буй автомашинуудыг үзлэг оношлогоонд графикийн дагуу оруулах.	Авто аж ахуйн хэсэг дотоод төлөвлөгөөгөөр хэрэгжүүлэх	Станцын автомашинуудыг графикт үзлэг оношлогоонд оруулсан. Албан бичиг хавсаргав
6		Үйлдвэрлэлд явуулахад шаардлагатай ажлын байруудаас гарч буй ахуйн хог хаягдал болон сэлбэг материалын хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын хогийн цэгт цуглуулах, хоёрдогч түхий эд болгож ашиглахаар ялгасан зүйлийг холбогдох цэг, үйлдвэрт тээвэрлэж хүргэх, борлуулах	Станцын үндсэн үйл ажиллагаа, бусад төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үед гарах хог хаягдлыг хариуцсан цех, нэгж аж ахуйтай хамтран ажиллана	Цех нэгжүүдэд хог хаягдлыг ангилан ялгах талаар үүрэг өгч тодорхой түвшинд хог хаягдлыг ангилан ялгаж байна. Станцын ариун цэвэрийн комисс 7 хоног бүр хуралдаж үүрэг даалгавар өгч биелэлтийг шалгаж байна.



Газрын гадарга, хөрс, ургамал				
7	Станцын үндсэн үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд коджуулах, өнөөгийн нөхцөл байдалд мэргэжлийн зөвлөхөөр үнэлгээ хийлгэж байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.	Үйлдвэрийн ажлын байр, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулж аюултай хог хаягдлын хэмжээг бууруулах	Бүх ажлын байр	Үндсэн болон туслах тоноглолын ашиглалт, засвараас гарсан аюултай хог хаягдлын хэмжээнд тогтмол хяналт тавьж мэргэжлийн байгууллагаар устгуулах гэрээ байгуулан ажиллаж байна.
8	Тээврийн хэрэгслийн явалт, ажилчдын хөлөөр хөрс эвдрэх, ургамал гэмтэх, эвдрэл үүсэхээс гадна шатах тослох материал, хог хаягдал,	Төслийн газар ашиглалттай холбоотой бичиг баримтыг бүрдлийг хангах онц шаардлагатайгаас бусад талбайд ашиглалт явуулахгүй байх арга хэмжээ авах	Дулааны цахилгаан станцын хэмжээнд	Эзэмшил газруудын баримт бичгийн бүрдлийг хангаж татварыг тухай бүрт төлж тооцоо нийлсэн акт үйлдэж ажилласан.
9	бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсэж болзошгүй	Дахин ашиглагдахгүй болсон талбайд тэмдэг тэмдэглэгээ байршуулж байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх	Дулааны цахилгаан станцын хэмжээнд	Дахин ашиглахгүй газрын нийслэлийн газрын албанд 2015 онд хүлээлгэн өгсөн. Шинээр 55 га газар эзэмшихээр авсан.
10		Станцын үндсэн үйл ажиллагаа явуулж буй газрын ногоон байгууламжийн тохижилтын хангаж тогмол арчилж тохижуулах	Үндсэн үйл ажиллагаа явуулж буй талбайд	Үйл ажиллагаа явуулж газрын тохижилт арчилгааг тогтмол хийж ажилласан.
Усан орчин				
11	Үйл ажиллагаанд ашиглаад гарсан саарал ус агуулах, хадгалах байгууламжуудын ус үл нэвчүүлэх хамгаалалт хагарах, цоорох, бохир ус дамжуулах хоолойд гэмтэл үүсэх, шатах тослох материал асгаралт зэрэг нь бохирдлын эх	Шинэ үнс хадгалах сангийн ойролцоо газрын доорх усанд хяналт хийх зориулалттай цооногийн мэдээллийг хянаж ажиллах.	Газрын доорх усны хяналтыг сайжруулах	Газрын доорх усны хяналтын цооногийг мэдээллийг хянаж ажилласан ямар нэгэн бохирдолтой гэсэн мэдээлэл ирээгүй. ТГСГЗахиргаа болон Усны газар хяналтын мэдээллийг шууд авахаар тоноглосон.
12		Станц өөрийн эзэмшлийн гүний худгууд, ус нөөцлөх бак, Тунгаах сангийн уснаас сар бүр дээж авч дотоод хяналтын лаборатороор дээж авхуулж хяналт тавьж ажиллана	Дотоод төлөвлөлтөөр	Дотоод хяналтын лабораторт долоо хоног, сар, улирал бүр дээж авч хяналт тавьж ажилласан.

	ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ	АШБ-ТБХ-09-2015
		Хувилбар 1


13	үүсвэр болно.	2024 оны Ус ашиглах дүгнэлт гаргуулж зөвшөөрөл авах, 2024 оны ус ашиглалтын гэрээ байгуулах	Ашиглах усны хэмжээгээр	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраар дүгнэлт гаргуулж Туул голын сав газрын захиргаатай гэрээ байгуулсан. Төлбөрийг холбогдох татварын албанд төлсөн.
----	---------------	---	-------------------------	--

Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг	Биелэлт
	1	2	3	4
1	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дундговь аймагт ногоон зурвас байгуулах	Бага настай мод тарина.	МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн №58 тоот зарлиг, МУ-ын засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол үндэслэв.	Эрчим хүчний сайдын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/218 тоот тушаалаар батладсан төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутагт дэвсгэрт 2830 ширхэг мод тарьсан. Ажлын гэрээ, гэрээ дүгнэсэн акт, тайлан хавсаргав.
2	Төслийн талбайн орчим нөлөөлөлд өртсөн талбайг нөхөн сэргээх	Станцын эзэмшил газар мод, сөөг огтлох, хөрс эвдэх, хог хаягдал асгах явдалд хяналт тавьж тохижуулалт хийх, ургамалжуулах	MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага	Мянганы сорилтын корпарацитай холбоотой нөхөн тарилт хийлгэн хяналт тавьж ажилласан
3		Ногоон байгууламж байгуулах талбайн хөрсийг үржил шимт хөрсөөр хучих, бэлтгэх		Ногоон байгууламжийн арчилгаа усалгаа
4		Ногоон байгууламжийн арчилгаа усалгаа		

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Биелэлт
	1	2	3	4
1	Химийн бодисын сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдах, орчинд тархах	Химийн бодис, сав баглаа нийлүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллана. (үйлдвэрт хадгалагдаж буй сав баглаа, боодлыг ариутгаж ашиглахаас гадна нөөцөд шинэ сав, баглаа боодол авч хадгалах)	Тавигдах шаардлага стандартыг хангасан бараа материал худалдан авах.	Химийн бодис нийлүүлэх болон сав баглаа боодол устгах тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.
2	Химийн бодисыг үйл ажиллагаа, тоног төхөөрөмжинд ашиглах явцад алдагдах эрсдлийн үед авах арга хэмжээ	Химийн бодис, ашиглалтын үед алдагдсан тохиолдолд саармагжуулах, цэвэрлэх багаж хэрэгсэлээр хангагдсан байх.	Ус, элс шороо, хүрз, цэвэрлэгээний бодис гэх мэт	Ажлын байр тус бүрт багаж хэрэгсэлээр хангаж ажилласан.
3	Байгалийн гамшигт үзэгдэл болсон тохиолдолд үндсэн үйл	Гамшгийн үеийн эрсдэлийн үнэлгээнд тодотгол хийлгэх	Мэргэжлийн байгууллагаар	Компанийн бизнес төлөвлөгөөний тодотголд оруулах

	ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ	АШБ-ТБХ-09-2015
		Хувилбар 1


ажиллагаанд хэрхэн нөлөөлөх тухай		саналыг ЭХЯ-нд хүргүүлсэн.
-----------------------------------	--	----------------------------

Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлт
	1	2	3	4
1	Ахуйн хог хаягдал	Хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж нэгдсэн хогийн цэгт нийлүүлэх.	Гадаа талбайд байршуулах	Хог хаягдлыг ангилан ялгах талаар ажилтнууд болон цехийн дарга нарт мэдээлэл хүргэн хяналт тавин ажиллаж байна. Технологи үйл ажиллагаанд ашигласан хаягдал усыг эргүүлэн ашиглаж хэвшсэн. Зохих журмын дагуу зааварчилгаа өгөгдсөн.
2	Ажлын байрууд	Ариутгал цэвэрлэгээний ажлыг тогтмол хийж байх	Хатуу хог хаягдлыг цуглуулж буй газар	
3	Үйлдвэрийн	Хаягдал усны дахин ашиглалтын хувь хэмжээг аль болох технологи үйл ажиллагаатай уялдуулж нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах.	Шингэн хаягдлын орчимд	
4	Аюултай	Химийн бодисын хадгалалт, ашиглалтыг зохих журмын дагуу хэрэгжүүлэх.	Холбогдох ажилтан албан хаагчдад үүрэг өгөх	

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Биелэлт	
	1	2	3	4	
Агаарын чанар					
1	<ul style="list-style-type: none"> ✓ Тоосжилт (PM₁₀, PSM, PM₂₅) ✓ Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ ✓ Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин) ✓ Бохирдлын цэгэн эх үүсвэр (O₂, SO₂, NO₂, CO) 	Зуухны яндангийн орчим	2024 он	Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатороор хэмжилт хийлгэсэн. Шинжилгээний дүн хавсаргав.	
2		Станцын эзэмшил газрын гадны талбайн орчинд		Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатороор хэмжилт хийлгэсэн. Шинжилгээний дүн хавсаргав	
3				Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатороор хэмжилт хийлгэсэн. Шинжилгээний дүн хавсаргав	
4		Нүүрс бутлах цехийн орчимд		Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатороор хэмжилт хийлгэсэн. Шинжилгээний дүн хавсаргав.	
5				Үнсэн сангийн орчимд	Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатороор хэмжилт хийлгэсэн. Шинжилгээний дүн хавсаргав.
6					
7				Станцын хажууд байрлах автобусны буудлын ойролцоо	Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатороор хэмжилт хийлгэсэн
8					Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатороор хэмжилт хийлгэсэн

	ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ	АШБ-ТБХ-09-2015
		Хувилбар 1

9	Үнсэн сан болон зуухны үнс баригч, нүүрснээс дээж авч цацрагийн шинжилгээ хийлгэнэ.	2024 он	Стандарт хэмжил зүйн газрын харьяа лабораторт дээж өгч шинжилгээ хийлгэв.	
Усан орчин				
10	РН, ХХХ, Хатуу бодисын хэмжээ, сульфид	Ашиглаж буй усны эх үүсвэр	2024 он	Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатороор хэмжилт хийлгэж дотоод хяналтын лабораторт хяналт хийсэн.
Хөрсөн бүрхэвч				
11	Хөрсний химийн болон биологийн, физик шинж чанар, хүнд металлын болон нянгийн бодирдлыг тодорхойлох	Үйл ажиллагаа явуулж буй талбайн орчмын хөрснөөс	2024 он	Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатороор хэмжилт хийлгэсэн
12	бодирдлыг тодорхойлох	Үнсэн сангийн орчмоос		

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хамрах хүрээ	Биелэлт
	1	2	3	4
1	Байгалийн гамшиг, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагын хүмүүстэй хамтран зохион байгуулах	ХАБЭА-н зардалд тусгагдсан	“ДЦС-3” ТӨХК-ийн хүрээнд	Станцын ажилтнуудад мэргэжлийн байгууллагатай хамтран танхимын болон ажлын байрны сургалт явуулсан.
2	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх нэгдсэн төлөвлөгөө батлуулах, хэрэгжүүлэх эрүүл мэндийн нөхцөлийн тодорхойлолт, хяналт-шинжилгээг тогтмол хийж хөдөлмөр хамгаалал болон болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, осол аваарын үед авах арга хэмжээний төлөвлөгөө гарган цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулах.	ХАБЭА-н зардалд тусгагдсан	“ДЦС-3” ТӨХК-ийн хүрээнд	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийгдсэн.

	ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ	АШБ-ТБХ-09-2015
		Хувилбар 1

3	Станцын ажлын байруудад яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлээр хангах.	ХАБЭА-н зардалд тусгагдсан	“ДЦС-3” ТӨХК-ийн хүрээнд	Ажлын байр тус бүрт анхан шатны тусламжийн хайрцаг, эм хэрэгсэл байршуулсан.
4	Станцын жилийн үйл ажиллагаанаас агаар мандалд хаягдсан бодисуудын төлбөрийг хуулийн хугацаанд төлөх.	Компаний бизнес төлөвлөгөөнд тусгагдсан / 49 сая.төгрөг /	“ДЦС-3” ТӨХК-ийн хүрээнд	Цаг уур орчны шинжилгээний газраар бохирдуулах бодисын хэмжээг тодорхойлуулж төлбөрийг харьяа татварын албанд төлсөн. Төлбөрийн баримт хавсаргав.
5	Хаягдал усны дүгнэлтийн дагуу ус бохирдуулсны төлбөрийг хугацаанд төлөх	Хаягдал усны дүгнэлтэнд заасан хэмжээ	“ДЦС-3” ТӨХК-ийн хүрээнд	Усны газраар хаягдал усны дүгнэлт гаргуулж Туул голын сав газрын захиргаатай гэрээ байгуулсан. Төлбөрийн баримт хавсаргав.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Биелэлт
	1	2	3	4
1	Нийслэлийн байгаль орчны газар	Тухайн жилийн БОМТ-ын хэрэгжилтийг дүгнүүлэх	Тухайн ашиглалтын жилд хэрэгжүүлсэн байгаль орчны арга хэмжээний тухай	Биелэлтийн тайлан гаргаж цахим системд хугацаанд нь оруулсан.
2	Хан-Уул дүүргийн 3-р хорооны засаг дарга	Тухайн жилийн БОМТ-ын хэрэгжилтийг танилцуулах		Станцын үндсэн үйл ажиллагаанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдэж холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан. Албан бичиг хавсаргав.
3	Хан-Уул дүүргийн 3-р хорооны иргэдийн хурал	Тухайн жилийн БОМТ-ын хэрэгжилтийг танилцуулах		Станцын үндсэн үйл ажиллагаанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдэж холбогдох албан тушаалтнуудад танилцуулсан. Албан бичиг хавсаргав.

Жич: Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг цахим системд оруулахад файлын хэмжээ 30 МВ-т байгаа нь зарим баталгаажуулсан зураг, мэдээлэл оруулах боломжгүй байгаа тул шаардлагатай нэмэлт мэдээллийг И-мэйл хаягаар явуулъя.

Төлөвлөгөөний биелэлт гаргасан:

“ДЦС-3” ТӨХК-ийн Үйлдвэрлэлийн экологийн инженер Э.Энхбат

Холбоо барих: 99001531

78025
Bard
06/24
③



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2024.02.01 № 01/135
танай 2024.01.08-ны № 1/56 -Т

“ДУЛААНЫ III ЦАХИЛГААН
СТАНЦ” ТӨХК-Д

Усны тухай хуулийн 28.4 дэх заалт, танай байгууллагын 2024 оны 1/56 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, холбогдох бичиг баримтыг судалж үзээд ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг: Туул голын сав газрын захиргаанд
Хавсралт: 4... хуудастай.

Ирээдүй хойч үедээ усны нөөцөө үлдээхийн төлөө
усаа хамгаалъя, хуримтлуулъя, хамтран ажиллая.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.БАТБАЯР

162430258

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2024 оны 02 дугаар
сарын 04-ны өдөр

Дугаар...8

Улаанбаатар
хот

1. Аж ахуйн нэгж, байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

"Дулааны III цахилгаан станц" ТӨХК, гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, ДЦС-III ТӨХК байр, утас/факс: 976-11-343024, цахим шуудан: ps3@tes3.energy.mn. Улсын бүртгэлийн дугаар: 9012001004, регистрийн дугаар: 2546191.

2. Төслийн нэр, байршил:

"Дулааны цахилгаан станц III" ТӨХК нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутагт байрлана. Туул голын сав газарт хамаарагдана.

3. Төсөл хэрэгжүүлэгч:

"Дулааны III цахилгаан станц" ТӨХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат: /X, Y/

- 14/2006 дугаартай цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл (төвийн бүсийн нэгдсэн сүлжээ)

- 15/2006 дугаартай дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл (Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн систем)

- 28/2004 дугаартай дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл ("Дулааны III цахилгаан станц" ТӨХК-ийн эзэмшлийн дулаан түгээх)

- 26/2004 дугаартай цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл ("Дулааны III цахилгаан станц" ТӨХК-ийн эзэмшлийн цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчид)

- 14/2015 дугаартай цахилгаан түгээх тусгай зөвшөөрөл ("Дулааны III цахилгаан станц" ТӨХК-ийн эзэмшлийн цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчид)

- 27/2004 дугаартай дулаан түгээх тусгай зөвшөөрөл ("Дулааны III цахилгаан станц" ТӨХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчид).

Улсын тусгай объектод хамаарах бөгөөд 88.5га газар эзэмшдэг. 2015 оны 12 сарын 23-ны өдрийн 000438716 дугаар бүхий газар эзэмших эрхийн гэрчилгээтэй.

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:

Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хангах, түгээх, худалдах.

6. Үйлдвэрийн техник, технологи: /ажиллах горим, хүчин чадал/

БЗК-220-100 маркийн уурын генератор 7 ш

ПТ-12-35/10 М маркийн турбин 4 ш

ПТ-25-90-10 М маркийн турбин 4 ш

35 МВт/ц чадалтай турбин генератор-1

БКЗ-75-39 маркийн уурын генератор 6 ш

ш

Нийт суурилагдах хүчин чадал 198 мВт. 2014 онд ТГ-9, С-50/8,8 параметртэй 50 мВт-ын өргөтгөл хийгдсэн. Ус хөргөх цамхаг, хими цех, нүүрсний агуулахтай. Станц 986 ажилтантай хоногт 4 ээлжээр, 365 хоног тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:

2024 онд 1,121,736.0 мВтцаг цахилгаан, эрчим хүч, 2,422,857.0 Гкал дулааны эрчим хүч, 232,000.0 Гкал уур үйлдвэрлэхээр төлөвлөсөн.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ: /шоо.метрээр/

Унд ахуйн хэрэглээний усыг нийслэлийн ус хангамжийн төвлөрсөн сүлжээнээс, техникийн хэрэглээний усыг өөрийн эзэмшлийн 18 худгаас ус авч ашигладаг.

9. Усны барилга байгууламжууд: /нэр, хүчин чадал, хэмжээ, хийц, дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/

Техникийн ус нөөцлөх 1,000.0 м³ багтаамжтай 1 ш бак, 846,000.0 м³ багтаамжтай үнсэн сан- 1 ш, 124,000.0 м³ багтаамжтай тунгаагдсан ус нөөцлөх сан-1 ш, галын аюулгүй байдлыг хангах 250.0 м³ багтаамжтай 2 ширхэг сантай. 57,600.0 м³ багтаамжтай үнсэн сан- 1 ш шинээр баригдсан.

Худгийн усыг өргөлтийн станцад 2x1,000.0 м³ санд хуримтлуулан өргөлтийн 1-р насосны тусламжтай 500.0 мм-ийн голчтой 6.0 км урт хос хоолойгоор дамжуулан станцын технологийн хэрэгцээнд ашигладаг.

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур: /насосны хүчин чадал, марк/

Сонсголонгийн гүүрний баруун талд байрлах техникийн усны эх үүсвэрийн нийт 18 худагтай бөгөөд үүнээс 4 нь засвартай ашиглалтаас хасагдсан.

Нэгдсэн шугам дээр UFM 005 маркийн усны тоолууртай, дулааны шугам сүлжээ, техникийн уурын шугам нэмэлт ус өгөх хоолойг тоолууржуулсан байна.

Худгийн дугаар	Уртраг	Өргөрөг	Гүн,м	Ундарга л/с	Насосны марк
№1	47°53'48"	106°47'45"	35.0	60.0	SP160-4-AA
№2	47°53'53.5"	106°47'32"	40.0	60.2	SP160-4-AA
№3	47°53'57.8"	106°47'19.1"	50.0	70.0	SP160-4-AA
№4	47°54'02"	106°47'04.5"	50.0	72.3	ЭЦВ-12-160-65
№5	47°54'05.5"	106°46'46.5"	41.0		Ашиглахгүй байгаа
№6	47°54'08.43"	106°46'46.6"	38.0		Ашиглахгүй байгаа
№7	47°54'11"	106°46'25"	42.0	55.6	ЭЦВ-12-120-60
№8	47°54'10.37"	106°46'09.17"	38.5	63.0	SP160-4-AA
№9	47°53'48"	106°45'45"	38.5	53.0	SP160-4-AA
№10	47°54'00"	106°47'58.6"	50.0		SP160-4-AA
№11	47°54'02.28"	106°45'32"	50.0	60.2	SP160-4-AA
№12	47°54'03.3"	106°45'18.18"	50.0	69.0	SP160-4-AA
№13	47°54'02.56"	106°45'02.8"	50.0		Ашиглахгүй байгаа
№14	47°54'01.52"	106°44'39.1"	39.0	51.6	ЭЦВ-12-160-65
№15	47°53'59.7"	106°44'15.24"	44.0	79.0	Ашиглахгүй байгаа
№16	47°54'20.41"	106°44'06"	44.0	69.0	SP160-4-AA
№17	47°54'12.86"	106°43'54.08"	47.0	47.0	SP160-4-AA
№18	47°54'13.3"	106°43'36.6"	40.0	77.0	SP160-4-AA

11. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:

"Үйл ажиллагааны болон шинээр баригдах үнсэн сан" төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2019 онд "Экологийн бүтээмж" ХХК хийж гүйцэтгэсэн.

12. Онцгой нөхцөл:

- Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариу дүнг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газарт ирүүлж, Усны тухай хуулийн 25.2-т зааснаар хаягдал усны дүгнэлт гаргуулах.

13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-301 дүгээр тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм"-ын дагуу станцын техник, технологийн усны хэрэглээг тооцоход:

Станцын техник болон технологийн ус хэрэглээ:

1,121,736.0 мВтц x 0.42 м³/мВтц = 471,129.12 м³

- Цахилгаан эрчим хүч боловсруулахад зарцуулах ус

$2,422,857.0 \text{ Гкал} \times 3.94 \text{ м}^3/\text{Гкал} = 9,546,056.58 \text{ м}^3$	- Усаар дулааны эрчим хүч боловсруулахад зарцуулах ус
$(232,000.0 \text{ Гкал} \times 2.0 \text{ тн}/\text{Гкал}) \times 1 \text{ м}^3/\text{тн} = 464,000.0 \text{ м}^3$	- Уураар дулааны эрчим хүч боловсруулахад зарцуулах ус
$471,129.12 \text{ м}^3 + 9,546,056.6 \text{ м}^3 + 464,000.0 \text{ м}^3 = 10,481,185.7 \text{ м}^3$	- Техник, технологийн хэрэгцээнд зарцуулах нийт усны хэмжээ
$1998 \text{ ш} \times 40 \text{ л}/\text{ш} \times 9 \text{ удаа} = 719.28 \text{ м}^3/\text{жил}$	- Мод, бут усалгаанд ашиглах ус
$986 \text{ хүн} \times 150 \text{ л}/\text{хон} \times 365 \text{ хон} = 53,983.50 \text{ м}^3/\text{жил}$	- Унд, ахуйн усны жилийн хэрэглээ

ДЦС-3 ТӨХК-ийн 2024 оны ус ашиглалтын төлөвлөгөө:

Эрчим хүч үйлдвэрлэхэд шаардлагатай **10,481,185.7 м³** усны **1,818,000.0 м³** усыг эргэлтийн усаар хангаж, станцын усан хангамжийн эх үүсвэрээс **8,663,185.7 м³** усыг шууд болон нөхөн сэлбэлтээр авч ашиглахаар тооцож тусгасан байна.

14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:

"Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай" хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу хүн амын унд-ахуйд хэрэглэх **53,983.50 м³** усны төлбөрийг ус ашигласны төлбөрөөс чөлөөлнө. Эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар ус хангамжийн эх үүсвэрээс шууд болон нөхөн сэлбэлтээр авч ашиглах **8,663,185.7 м³** газрын доорх усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Туул голын сав газарт тогтоосон усны экологи-эдийн засгийн суурь үнэ, 2013 оны 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, 2013 оны 326 дугаар тогтоолд заасан усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг ашиглан урьдчилсан байдлаар тооцвол:

Эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар усны нөөц ашигласны төлбөр:

1м³ усны нөөц ашигласны төлбөр: $9440 \text{ төг}/\text{м}^3 \times 0.15 \times 0.05 = 70.8 \text{ төг}$

9440 төг/м³ – Туул голын сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

15% – Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 8-д заасан хувь, хэмжээ

0.05 – Эрчим хүчний зориулалтаар газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох ашиглалтын зориулалтын итгэлцүүр

$8,663,185.7 \text{ м}^3 \times 70.8 \text{ төг}/\text{м}^3 = 613,353,547.56 \text{ төг}$

Ногоон байгууламжийн усалгаа, мод тарихад ашиглах газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

1м³ усны нөөц ашигласны төлбөр: $9440 \text{ төг}/\text{м}^3 \times 0.1 \times 0.08 = 75.52 \text{ төг}$

9440 төг/м³ – Туул голын сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ

10 % – Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 9-д заасан хувь, хэмжээ

0.08 – Ногоон байгууламжийн зориулалтаар газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох

ашиглалтын зориулалтын итгэлцүүр

$719.28 \text{ м}^3 \times 75.52 \text{ төг}/\text{м}^3 = 54,320.02 \text{ төг}$

Нийт төлбөр: $613,353,547.56 \text{ төг} + 54,320.02 \text{ төг} = 613,407,868.0 \text{ төг}$

/Зургаан зуун арван гурван сая дөрвөн зуун долоон мянга найман зуун жаран найман төгрөг/

15. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар:

- Үнс зайлуулж буй усыг тунгааж, зохих стандартын шаардлагад нийцүүлэн эргүүлэн техник, технологийн хэрэгцээ, тоосжилт дарах усалгаанд ашиглах.



16. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

- Усны тухай хуулийн 28.6, 29.1 дэх заалтуудыг үндэслэн Туул голын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу баталгаажуулсан тоолуурын заалтаар байгалийн нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх;
- Усны тухай хуулийн 31.2-т зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар шатлан өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;
- Усны тухай хуулийн 24.3-т заасны дагуу үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед сав газрын захиргаа болон төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж ажиллах;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан (усны хяналт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн тухай акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2024 оны 12 дугаар сарын 20-ны дотор "Усны газар"-т office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлэх;

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х. Мянмаржав Х.МЯГМАРЖАВ



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар УНТ 24/01

2-3-92/24

Нэг. Ерөнхий зүйл

Улаанбаатар хот

Монгол Улсын Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Усны газрын 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 01/135 дугаар албан бичгээр ирүүлсэн 8 дугаар ус ашиглуулах дүгнэлт, Туул голын сав газрын захиргааны даргын 2024 оны 2 дугаар сарын 9-ны өдрийн А/03 дугаар тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Цогт, Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө Улсын бүртгэлийн 9012001004 тоот гэрчилгээ, 2546191 тоот регистрийн дугаартай “Дулааны 3-р цахилгаан станц” ТӨХК-ийн Ерөнхий инженер Н.Чимиддорж нар ус ашиглах талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаагаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт:

- 1.1.1. Унд ахуйн хэрэгцээнд ашиглах ус;
- 1.1.2. Мод, бут усалгаанд ашиглах ус;
- 1.1.3. Уураар дулааны эрчим хүч боловсруулахад зарцуулах ус;
- 1.1.4. Усаар дулааны эрчим хүч боловсруулахад зарцуулах ус;
- 1.1.5. Цахилгаан эрчим хүч боловсруулахад зарцуулах ус.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 10'535'888.48

- 2.2.1. Унд ахуйд ашиглах ус: 53'983.5 м³/жил;
- 2.2.2. Мод, бут усалгаанд ашиглах ус: 719.28 м³/жил;
- 2.2.3. Уураар дулааны эрчим хүч боловсруулахад зарцуулах ус: 464'000.0 м³/жил;
- 2.2.4. Усаар дулааны эрчим хүч боловсруулахад зарцуулах ус: 9'546'056.58 м³/жил;
- 2.2.5. Цахилгаан эрчим хүч боловсруулахад зарцуулах ус: 471'129.12 м³/жил.

2.3. Усны чанар, найрлага: Унд ахуйн болон үйлдвэрийн технологийн уснаас улирал тутам дээж авч шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг Ус ашиглалтын тайланд хавсарган Туул голын сав газрын захиргаанд ирүүлэх.

2.4. Усны эх үүсвэр:

- 2.4.1. Байршил: Сонсголонгийн гүүрнээс баруун тийш Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт Туул голын хойд эргийн дагуу байрлах 18 гүний худагтай, 1979 онд “ПНИИИС” газрын доорх усны ашиглалтын нөөцийг 41'400.0 м³/хон, 2013 онд “Цэнхэр эрдэнэ” ХХК 32'400.0 м³/хон гэж тооцсон байна. Одоогоор 14 худгийг ашиглаж байгаа бөгөөд 5, 6, 13, 14 дугаартай худгуудын ундарга муудсан учир ашиглахгүй байна;

- 4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;
 - 4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол;
 - 4.5.3. Ус ашиглах гэрээний үүргээ ноцтойгоор зөрчсөн;
 - 4.5.4. Ус ашиглах зөвшөөрөл цуцлагдсан.
- 4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах
албаны дарга


 П.ЭНХБАЯР/
Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалт
хариуцсан мэргэжилтэн
 Н.ЦОГТ/

Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД, 2-р
хороо, Чингүнжавын гудамж, Туул голын
сав газрын захиргааны байр, 203 тоот.
Харилцах утас: (976) 70003714.

УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ДЦС-3" ТӨХК-ийн Ерөнхий инженер
 Н.ЧИМЭДДОРЖ/

"ДЦС-3" ТӨХК-ийн Техникийн
бодлогын хэлтсийн дарга

 Г.АМАРТҮВШИН/
"ДЦС-3" ТӨХК-ийн хуулийн
мэргэжилтэн

 Ц.ОЮУН-ЭРДЭНЭ/
"ДЦС-3" ТӨХК-ийн Гэрээний
мэргэжилтэн

 Г.БАТНЯМ/

Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө.

Харилцах утас: 1134-3024.
9900-1531.

СБД-с
Талбарын
Баримт
2024.04.03
Хан-Уул



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

УСНЫ ГАЗАР

Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Тас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.gov.mn

2024.04.03 № 01/389
танай 2024.02.07-ны № 1/189 -Т

“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Л.ЭРХБААТАР ТАНАА

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг болон танай ирүүлсэн 2024 оны 1/189 тоот хүсэлтийг тус тус үндэслэн 2023 оны хаягдал усны дүгнэлтийг гаргаж, ус бохирдуулсны төлбөрийг тооцон хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг: Туул голын сав газрын захиргаа, Хан-Уул дүүргийн Татварын хэлтэст.

Хавсралт: ... хуудастай.

Ирээдүй хойч үедээ усны нөөцөө үлдээхийн төлөө усаа хамгаалъя, хуримтлуулъя, хамтран ажиллая.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.БАТБАЯР

162430689

ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2024 оны 04 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот
Утас:51-265540

1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар, утас: 976-11343024, 99001531, Улсын бүртгэлийн дугаар: 9012001004, Регистрийн дугаар: 2546191.

2. Төслийн нэр, байршил

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэх станц нь Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороонд байрладаг бөгөөд Туул голын сав газарт хамаарч байна.

3. Хаягдал ус хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга, түвшин:

"Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК нь унд ахуйн хэрэглээнээс гарсан ахуйн бохир усыг Улаанбаатар хотын "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ-ын төвийн Ф1,400 мм-ийн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлдэг бөгөөд технологийн хаягдал усыг 785'000 м³ эзлэхүүнтэй үнсэн сан, 57'600 м³ эзлэхүүнтэй тунгаах санд механик аргаар цэвэрлэн, эргүүлэн ашигладаг байна. Тунгаах сангийн илүүдэл усыг 150 м³/цаг хүчин чадалтай гүн цэвэрлэгээний "Ус цэвэршүүлэх байгууламж"-д цэвэрлэн, Туул голын голдирол дагуу нийлүүлдэг.

4. Хаягдал усны хэмжээ:

Бохир усны тоолуур суурилуулаагүй тул технологийн хаягдал усны хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6.3 дахь заалтад заасны дагуу цэвэр усны шугам дээр суурилуулсан хэмжих хэрэгслийн заалтаар тодорхойлсон усны эзлэхүүнээс үйлдвэрлэл, үйлчилгээний бүтээгдэхүүнд шингэсэн усны эзлэхүүнийг хасаж тооцоход 956,700.0 м³/жил, дахин ашигласан хаягдал ус 1,818,000.0 м³/жил байна. Унд ахуйн хаягдал усны хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017 оны 74 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн харилцааны дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасны дагуу "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ-ын борлуулалтын орлогын бичилтийг үндэслэн тооцоход 59,976.0 м³/жил байна.

5. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл:

Унд ахуйн хаягдал усанд 2023 оны I, II, IV улиралд, үнсэн сангийн технологийн хаягдал усанд 2023 онд лабораторийн сорьцын шинжилгээ хийлгээгүй тул Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны А-816/218 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ"-г үндэслэн бохирдуулах бодисын хэмжээг технологид бусад үйлдвэрлэл 0.4 кг/м³, унд ахуйд бусад үйлчилгээ 0.8 кг/м³-ээр тооцов.

6. Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ", Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлал"-ыг тус тус үндэслэн тооцоход **21,248,916.88** /хорин нэгэн сая хоёр зуун

дөчин найман мянга есөн зуун арван зургаан төгрөг наян найман мөнгө/ төгрөг ногдож байна.

7. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ

-Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.13 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу Туул голын сав газрын захиргаагаар "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг", "Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ"-г дүгнүүлж, сунгуулах;

-Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар баталсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулах;

-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны А-406/226 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усны эзлэхүүн, бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцоолох аргачлал"-ын хүснэгт №2-ын 22, 32-д заасан хаягдал усанд тодорхойлох үзүүлэлтүүдийг бүрэн шинжлүүлээгүй тохиолдолд бохирдуулах бодисыг жишиг хэмжээгээр авч тооцно;

-“Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандартын шаардлагыг хангасан хаягдал усыг байгальд нийлүүлэх, “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх аягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015” стандартын шаардлагыг хангасан хаягдал усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх, стандартаас давсан бол Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, БОАЖ-ын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар баталсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах;

-Ус бохирдуулсны төлбөрийг улирал бүр тооцуулах, хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд хүсэлтийг e-mongolia.mn цахим системээр ирүүлэх;

-Ус бохирдуулсны төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлөх;

-Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг, хаягдал усны шинжилгээний дүгнэлтүүд, төлбөр төлсөн баримтыг Усны газрын office@water.gov.mn цахим хаягаар 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэх.

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Л.ХИШИГДУЛАМ

“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН 2023 ОНЫ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТООЦОО

№	Бохирдуулах бодисын төрөл	Шинжилгээний давтамж	MNS 4943:2015 стандартын ЗДХ	Бохирдуулах бодисын дундаж агууламж		Хаягдал усны хэмжээ, м ³	Бохирдуулах бодисын хэмжээ, кг	Бодис тус бүрийн төлбөрийн хэмжээ		Ус бохирдуулсны төлбөр, төгрөгөөр
				мг/л	кг/м ³			хэмжих нэгж	тариф	
1	2	3	4	5	6	7	8=5*7*(10) ⁻³	9	10	11=8*10
1	Органик бодис /XXXI/	0	800	800	0.8	30,090	24072.00	төг/кг	50	1,203,600.00
2023 оны I, II улирлын унд ахуйн хаягдал усны төлбөр, төгрөгөөр										
1	Жинлэгдэх бодис	1	400	222	0.222	15125	3357.75	төг/кг	50	167,887.50
2	Органик бодис /XXXI/	1	800	202.3	0.2023	15125	3059.79	төг/кг	50	152,989.38
2023 оны III улирлын унд ахуйн хаягдал усны төлбөр, төгрөгөөр										
1	Органик бодис /XXXI/	0	800	800	0.8	14,761	11808.80	төг/кг	50	590,440.00
2023 оны IV улирлын унд ахуйн хаягдал усны төлбөр, төгрөгөөр										
1	Органик бодис /XXXI/	0	50	400	0.4	822,660	329064.00	төг/кг	50	16,453,200.00
2023 оны нөхөн сэлбэлтээр авсан технологийн хаягдал усны төлбөр, төгрөгөөр										
1	Органик бодис /XXXI/	0	50	400	0.4	1,818,000	727200.00	төг/кг	50	36,360,000.00
2023 оны тунгаах сангаас дахин ашигласан технологийн хаягдал усны төлбөр, төгрөгөөр										
1	Органик бодис /XXXI/	0	50	400	0.4	134,040	53616.00	төг/кг	50	2,680,800.00
2023 оны тунгаах сангийн дараах шүүлтүүрийн хаягдал усны төлбөр, төгрөгөөр										
2023 оны нийт төлбөр, төгрөгөөр										
Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасны дагуу дахин ашигласан технологийн хаягдал усны төлбөрийг 100% чөлөөлөхөд Улсын төсөвт төвлөрүүлэх ус бохирдуулсны төлбөрийн дүн:										21,248,916.88

БАТЛАВ
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НЯМДОРЖ

5633648
УЖА0053

БАТЛАВ
"ДУЛААНЫ III ЦАХИЛГААН СТАНЦ"
ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ

Л.ЭРХБААТАР

УЛААНБААТАР
ДУЛААН
ГУРАВДУГААР
ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨХК
УЖМ0063 246191
1116224986

ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ
БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ

2024 оны 04 дүгээр
сарын 09-ны/ний өдөр

Дугаар ХУТ 24/08,
2-3-198/24
Нэг. Ерөнхий зүйл

Улаанбаатар хот

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтад заасны дагуу Усны газрын гаргасан 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 67 дугаар хаягдал усны дүгнэлт, Туул голын сав газрын захиргаанаас олгосон 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 22/10 дугаар ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж: Туул голын сав газрын захиргааны Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Цогт, нөгөө талаас Ус бохирдуулагчийг төлөөлж: 9012001004 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 2546191 тоот регистрийн дугаартай "Дулааны III цахилгаан станц" ТӨХК-ийн Ерөнхий инженер Н.Чимиддорж нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 1 жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтад заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усны дүгнэлтээр тогтоосон ус бохирдуулсны төлбөр болох **21'248'916.88** /Хорин нэгэн сая хоёр зуун дөчин найман мянга есөн зуун арван зургаан төгрөг наян найман мөнгө/ төгрөгийг гэрээний 2.3-т заасан хугацаанд төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтад заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор үндсэн бүртгэлтэй харьяалах Татварын албанд төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутам Туул голын сав газрын захиргаа, харьяалах Татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.4.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

2.4.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинаар байгальд хаясан хаягдал усны хэмжээ;

2.4.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.4.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;

2.4.5. Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан;

2.4.6. 2.4.1-ээс 2.4.4-т заасан мэдээллийг tuulrba@gmail.com цахим хаягаар ирүүлнэ.

Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь хэсэгт заасны дагуу Сав газрын газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх хэсэгт заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно.

3.3. Сав газрын захиргаа болон сум, дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны эзлэхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл (тоолуур)-ийг "Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам"-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаанд суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

Тав. Бусад

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйл

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл (газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт)-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах
албаны дарга

...../П.ЭНХБАЯР/

Уул уурхай, эрчим хүчний ус
ашиглалтын асуудал хариуцсан
мэргэжилтэн

...../Н.ЦОГТ/

Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД,
2-р хороо, Чингүнжавын гудамж,
Туул голын сав газрын захиргааны
байр, 203 тоот өрөө.
Харилцах утас: 7000-3716, 7000-3714.

УС БОХИРДУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ДЦС-3" ТӨХК-ийн Ерөнхий инженер

 /Н.ЧИМЭДДОРЖ/


"ДЦС-3" ТӨХК-ийн Техникийн бодлогын
хэлтсийн дарга

 /Г.АМАРТҮВШИН/

"ДЦС-3" ТӨХК-ийн Ерөнхий нягтлан бодогч

 /О.ЭНХБАЯР/

"ДЦС-3" ТӨХК-ийн хуулийн мэргэжилтэн

 /Ц.ОЮУН-ЭРДЭНЭ/



"ДЦС-3" ТӨХК-ийн Гэрээний мэргэжилтэн

 /Г.БАТНЯМ/

Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө.

Харилцах утас: 1134-3024,
9900-1531.


ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР № 00000508

Огноо:	2024-04-10	Дансны дугаар	Дүн /тоогоор/
Төлөгч:	ДЦС-3 ТӨХК	Дебит	21,248,916.88
Төлөгчийн:	Голомт Банк	1102037031	
Хүлээн авагч:	Том татвар төлөгчийн газар	Кредит	
Хүлээн авагчийн:			
Мөнгөний дүн тоогоор (үсгээр)	21,248,916.88 хоногийн . . . хувийн торгууль . . .	
(Хорин нэгэн сая хоёр зуун дөчин найман мянга есөн зуун арван зургаан төгрөг 88 мөнгө)	 төгрөг мөнгө	
Барааг хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн:		Дүн (торгуулийн хамт)	
Дагалдах баримтын №	Огноо: 2024-04-10	****	
Төлбөрийн зориулалт (барааны болон ажил үйлчилгээний нэр)		Гүйлгээний утга	
	№3240402096647 Ус бохирдуулсаны төлбөр	(Төлбөрийн зориулалт)	
Тамга	Гүйцэтгэх захирал: 	Банкинд гүйлгээ хийсэн	Төлөх хугацаа
	Ерөнхий нягтлан бодогч: 	... оны ... сарын ...	Төлбөрийн ээлж
		(тэмдэг, гарын үсэг)	

ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР № 00001958

Огноо:	2023-12-28	Дансны дугаар	Дүн /тоогоор/
Төлөгч:	ДЦС-3 ТӨХК	Дебит	47,244,406.00
Төлөгчийн:	Төрийн Банк	105400001612	
Хүлээн авагч:	Том татвар төлөгчийн газар	Кредит	
Хүлээн авагчийн:			
Мөнгөний дүн тоогоор (үсгээр)	47,244,406.00 хоногийн . . . хувийн торгууль . . .	
(Дөчин долоон сая хоёр зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун зургаан төгрөг 00 мөнгө)	 төгрөг мөнгө	
Барааг хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн:		Дүн (торгуулийн хамт)	
Дагалдах баримтын №	Огноо: 2023-12-28	****	
Төлбөрийн зориулалт (барааны болон ажил үйлчилгээний нэр)		Гүйлгээний утга	
№3231202775316 Томоохон эх үүсвэрийн агаарын бохирдлын төлбөр		(Төлбөрийн зориулалт)	
Тамга	Гүйцэтгэх захирал: 	Банкинд гүйлгээ хийсэн	Төлөх хугацаа
	Ерөнхий нягтлан бодогч: 	2023 оны 12 сарын 28	Төлбөрийн эзлж
		(тэмдэг, гарын үсэг)	





ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД МОД ТАРИХ АЖЛЫН ГЭРЭЭ

2024 оны 05-р сарын 28 ны өдөр

Дугаар 2-3-278/24

Улаанбаатар хот

Нэг талаас "ДЦС-3" ТӨХК-ийг төлөөлөн Ерөнхий инженер Н.Чимэддорж (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас "Чандмань хархираа" ХХК-ийг төлөөлөн Гүйцэтгэх захирал Б.Ариунчимэг (цаашид "Гүйцэтгэгч" гэх) дараах нөхцөл, зүйлийг харилцан тохиролцож Иргэний хуулийн 243-261 дэх заалт, Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу ДЦС3/20240103121 дугаартай тендерт Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний зорилго оршино.

1. Захиалагч Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих (ДЦС3/20240103121) (цаашид "ажил" гэх)-ыг 154,000,949.00 (нэг зуун тавин дөрвөн сая есөн зуун дөчин есөн) төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
2. Гэрээний нийт дүн: 154,000,949.00 (нэг зуун тавин дөрвөн сая есөн зуун дөчин есөн) төгрөг байна. Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулан захиалагчид ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногт багтаан гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн шилжүүлнэ.
3. Гэрээт ажлын чанарын баталгааны 5% буюу 7,700,047.00 (долоон сая долоон зуун мянга дөчин долоо)-н төгрөгийг баталгаат хугацаа дуусгавар болсны дараа хуралдааны тэмдэглэлийг үндэслэн олгоно.
4. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор бүрэн хийж гүйцэтгэн Захиалагчид актаар хүлээлгэн өгнө.
5. Гүйцэтгэгч тал модны арчилгааг хүлээлгэн өгсөн акт үйлдсэнээс хойш 3 жилийн хугацаанд хариуцаж нөхөн тарилтыг хийж гүйцэтгэнэ.

Чимэддорж



“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ДУНДГОВЬ АЙМАГТ МОД ТАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР, ЭЗЛЭХҮҮН

Ажлын үндэслэл, зорилго:

Монгол Улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн №58 тоот зарлиг, МУ-ын засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/218 тоот тушаалийн хэрэгжилтийг хангаж Эрчим хүчний салбарын хэмжээнд ногоон хэрэм байгуулах ажлын хүрээнд Дундговь аймагт үе шаттайгаар нэг зуун мянган мод тарих ажлыг хэрэгжүүлэхэд оршино.

АЖЛЫН ТОО, ХЭМЖЭЭ:

№	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
Мод суулгахад шаардлагатай бэлтгэл ажил хангах				
1	Усалгааны систем	га	2	
2	Ёмкост /цэвэр усны/	ш	1	
3	Усалгааны мотор	га	1	
4	Тээвэр	Аймаг	1	
5	Нүх ухах	ш	2830	
6	Био ялзмаг, бордоо	ш	2830	
7	Тарилт	ш	2830	
8	Модны суулгац	ш	2830	
9	Чийг баригч	ш	2830	
10	Хашаа	га	2	
Мод суулгах, дагалдах хэрэгсэл угсралтын ажил				
1	Тухайн бүс нутагт ургах боломжтой мод суулгах	ш	2830	MNS 6139:2010, MNS 6140:2010
2	Суулгасан мод тус бүрт био-ялзмаг, усалгаа хийх.	ш	2830	
3	Суулгасан мод, бут орчмын талбайг цэвэрлэх	2	га	
4	Усалгааны системийг ажилд залгах	ш	2830	
5	Хүлээлгэн өгөх	ш	2830	

ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ:

№	Нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	Тайлбар
Машин, механизм				

1	Ачааны машин	1 тн-оос дээш даацтай	1	
2	Усны машин	1 м3-ээс дээш багтаамжтай	1	
3	Модны суулгах нүх ухах зориулалт бүхий өндөр хүчин чадалтай трактор дагалдах хэрэгслийн хамт	Өндөр хүчин чадалтай	1	
Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж				
1	Усалгааны системийг угсрах, шилжүүлэх зэрэг бусад дагалдах ажилд шаардлагатай багаж хэрэгсэл	Ажил гүйцэтгэхэд тохирох	ком	
2	Хүрз		5	
3	Жоотуу		5	
4	Тармуур		5	
5	Шороо зөөх тэрэг		3	
6	Хувин		10	
7	Хэмжих метр		2	

АЖИЛЛАХ ХҮЧ, ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл:	Албан тушаал	Хүний тоо	Туршлага/жил/	Мэргэжил
	Ерөнхий инженер буюу төслийн удирдагч	1	15 болон түүнээс дээш	Ойн инженер
	Талбайн инженер	1	5 болон түүнээс дээш	Ойн инженер
	ХАБЭА-ын ажилтан	1	1 болон түүнээс дээш	Сургалтанд хамрагдсан
	Эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан	1	1 болон түүнээс дээш	Сургалтанд хамрагдан
	Туслах ажилчин	5	1 болон түүнээс дээш	Сургалтанд хамрагдсан
	Жолооч	1	3 жил	Жолооч

ТӨСЛИЙН БАЙРШИЛ:

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих газрын кадастрын зураг



БАТЛАВ:
"ДЦС-3" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Л.ЭРХБААТАР

БАТЛАВ:
"ЧАНДМАНЬ ХАРХИРАА" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.АРИУНЧИМЭГ

ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД МОД ТАРИХ АЖЛЫН 2-3-276/24 ТООТ ГЭРЭЭ ДҮГНЭСЭН АКТ

2024.07.16

Улаанбаатар хот

Нэг талаас "Чандмань хархираа" ХХК /цаашид "Гүйцэтгэгч" гэх/, нөгөө талаас "ДЦС-3" ТӨХК /цаашид "Захиалагч" гэх/-ийн хооронд 2024 оны 05-р сарын 28-ны өдөр байгуулсан "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлын гэрээ" /цаашид "Гэрээ" гэх/-ний үүргийн биелэлтийг харилцан тохиролцож дүгнэв.

1. Захиалагч нь МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, МУЗГ-ын 350 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын А/218 дугаар тушаалыг хэрэгжүүлэхээр Чандмань хархираа ХХК-тай "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлын гэрээ" байгуулж хамтран ажилласан бөгөөд гүйцэтгэгч талын ирүүлсэн ажлын гүйцэтгэл, тайлан болон Дундговь аймаг Сайнцагаан сумын засаг даргын тамгын газраас ирүүлсэн албан тодорхойлолттой танилцсан бөгөөд ажлын даалгаварт тусгагдсан суулгацын тоо хэмжээ, усалгааны системийг хийж гүйцэтгэсэн байна. /Холбогдох тайланг хавсаргав./
2. Гүйцэтгэгч нь гэрээний хугацаанд техникийн тодорхойлолтод заасан MNS6139:2010, MNS6140:2010 стандартын шаардлага хангасан навчит модны суулгацыг Дундговь аймаг Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт 2 га газарт ногоон зурвас үүсгэж, 2830 ширхэг навчит суулгац суулгаж, гүний худаг өрөмдөж 144 метрээс ус гаргасан, иж бүрэн усалгааны систем, 600 метр хамгаалалтын хашаа барих ажлыг 2024 оны 06-р сарын 01-ний өдрөөс 07-р сарын 01-ний хооронд хийж гүйцэтгэн захиалагч талд хийсэн ажлын тайланг хүргүүлсэн. /Холбогдох тайланг хавсаргав./
3. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу тарьсан 2830 ширхэг навчит модны суулгац болон усалгааны иж бүрэн системийг Дундговь аймаг Сайнцагаан сумын захиргаанд 2024 оны 07-р сарын 05-ны өдөр хүлээлгэн өгсөн. Гүйцэтгэгч тал ургах чадваргүй болсон модны суулгацыг ухаж авах, нөхөн тарилт хийх ажлыг 3 жилийн турш арчлах, гадны хүчин зүйлээс хамгаалж, хамгаалалтын зурвасын амьдралтын хувийг 75%-аас доошгүй байлгахгаар Сайнцагаан сумтай хамтран хариуцаж ажиллана.

4. Захиалагч нь ажлын хөлс 154,000,949.00 (нэг зуун тавин дөрвөн сая есөн зуун дөчин есөн) төгрөгөөс чанарын баталгааны төлбөр болох 7,700,047.00 (долоон сая долоон зуун мянга дөчин долоо)-н төгрөгийг хасаж, үлдэгдэл 146,300,902.00 (нэг зуун дөчин зургаан сая гурван зуун мянга есөн зуун хоёр) төгрөгийг гэрээ дүгнэсэн өдрөөс хойш 45 хоногт багтаан гүйцэтгэгчийн ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн шилжүүлнэ.
5. Гэрээ хэрэгжих явцад ямар нэгэн маргаантай асуудал гараагүй болно.

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий инженер

 Н.Чимэддорж

Техникийн бодлогын хэлтсийн
дарга

 Г.Амартүвшин


Төлөвлөлт эдийн засгийн
хэлтсийн дарга

 Л.Оюун-Эрдэнэ


Хангамжийн хэлтсийн
дарга

 Н.Дашдэнзэн

Ерөнхий нягтлан бодогч


 О.Энхбаяр

Гэрээний мэргэжилтэн

 Г.Батням

Хянасан:

Хуулийн мэргэжилтэн

 Ц.Оюун-Эрдэнэ

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий менежер

Ү.Зоригтбаатар





**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Буяанзэмхийн өргөн чөлөө 3-315. 7-р баг. Сайнцагаан
сум, Дундговь аймаг. 48090 Утас: 70593808
Цахим хаяг: saintsagaan@dundgovi.gov.mn

2024.07.05 № 02/355

танай _____ -ны № _____ -т

Г ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-3 Г
ТӨХК-д

[Handwritten signature]


[Handwritten signature] 08/24
[Handwritten initials]

Тодорхойлолт

Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар тоот зарлиг, Монгол улсын засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2021 оны А/218 тоот тушаалын хэрэгжилтийг хангаж Эрчим хүчний салбарын хэмжээнд ногоон хэрэм байгуулах ажлын хүрээнд Дундговь аймагт үе шаттайгаар нэг зуун мянган мод тарих ажлыг хэрэгжүүлэх ажлын дагуу Дулааны цахилгаан станц-3 ТӨХК-аас зарласан "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих" ДЦСЗ/20240103121 дугаартай гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт шалгарч 2-3-276/24 тоот "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих" ажлын гэрээ байгуулан ажилласан Чандмань хархираа ХХК нь Сайнцагаан сумын 5 дугаар багийн нутагт дэвсгэрт орших Арвижих төгөлд 2га газарт ногоон зурвас байгуулах гүйцэтгэгчээр ажилласан.

Ногоон зурвас байгуулах ажлын хүрээнд гүний худаг ерөмдөж 144м ус гаргасан, иж бүрэн усалгааны системтэй 600м хамгаалалтын хашаа барьж, 2830 ширхэг навчит модны суулгац тарьж арчлах зэрэг ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан нь үнэн болно.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ

02/355

ЧАНДМАНЬ ХАРХИРАА
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТ КОМПАНИ

Монгол Улс Увс аймаг Улаангом сум 2-р баг
Чандмань тур амралт өөрийн байр
Утас : (978) 99188270, 99980509
И-мэйл: bandiinar@gmail.com

2024.07.02 № 44/24
танай _____-ны № _____-т

Ажлын гүйцэтгэл гаргах тухай

ДЦС-3 ТӨХК-д

[Handwritten signature]
[Handwritten signature]

[Handwritten signature] 04/24
[Handwritten signature]

МУ-ын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн №58 тоот зарлиг, МУ-ын засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/218 тоот тушаалийн хэрэгжилтийг хангаж Эрчим хүчний салбарын хэмжээнд ногоон хэрэм байгуулах ажлын хүрээнд Дундговь аймагт үе шаттайгаар нэг зуун мянган мод тарих ажлыг хэрэгжүүлэх ажлын дагуу ДЦС-3 ТӨХК-аас зарласан "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих" ДЦС3/20240103121 дугаартай гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт манай компани шалгарч 2-3-276/24 тоот "Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих" ажлын гэрээ байгуулан ажиллаж байгаа билээ.

Гэрээнд заасны дагуу тус ажлыг Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт орших 2 га газарт гүйцэтгэсэн ба тус газарт гүний худаг гаргах, иж бүрэн усалгааны системтэй болгох, хамгаалалтын хашаа барих, 2830 ш навчит модны суулгац тарьж арчлах зэрэг ажлыг 2024 оны 06 сарын 01-ний өдрөөс 2024 оны 07 сарын 01-ний хооронд хувиарын дагуу ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан тул ажил хүлээлцэх болмжоор хангаж өгнө үү.

Хүндэтгэсэн:

ЗАХИРАЛ

[Handwritten signature]

Б.АРИУНЧИМЭГ

ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
МОД ТАРИХ АЖИЛ

Handwritten signature
18/24
Handwritten mark

АЖЛЫН ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧ: ДЦС-3 ТӨХК
ГҮЙЦЭТГЭСЭН: ЧАНДМАНЬ ХАРХИРАА ХХК

БАТЛАВ: ЧАНДМАНЬ ХАРХИРАА ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Handwritten signature

Б.АРИУНЧИМЭГ

“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ДУНДГОВЬ АЙМАГТ МОД ТАРИХ АЖЛЫН ТАЙЛАН

АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО:

Монгол Улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн №58 тоот зарлиг, МУ-ын засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/218 тоот тушаалийн хэрэгжилтийг хангаж Эрчим хүчний салбарын хэмжээнд ногоон хэрэм байгуулах ажлын хүрээнд Дундговь аймагт үе шаттайгаар нэг зуун мянган мод тарих ажлыг хэрэгжүүлэхэд оршино.


ДЦС-3 ТӨХК-иас зарласан “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд мод тарих гүйцэтгэгийг сонгон шалгаруулах ДЦСЗ/20240103121 дугаартай тендерт “Чандмань хархираа” ХХК шалгарч 2024 оны 05 сарын 28-ний өдөр 2-3-276/24 тоот “Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих ажлын гэрээ” байгуулан ажилласан ба ажлын гүйцэтгэлийг Дундговь аймгийн Сайнцагаан сумын 5-р багийн нутаг дэвсгэрт орших 2га газарт 2024 оны 06 сарын 01 ний өдрөөс 2024 оны 07 сарын 01-ний хооронд ажлын хуваарийн дагуу бүрэн хийж гүйцэтгэлээ.

АЖЛЫН ТОО, ХЭМЖЭЭ:

№	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
Мод суулгахад шаардлагатай бэлтгэл ажил хангах				
1	Усалгааны систем	га	2	
2	Ёмкост /цэвэр усны/	ш	1	
3	Усалгааны мотор	га	1	
4	Тээвэр	Аймаг	1	
5	Нүх ухах	ш	2830	
6	Био ялзмаг, бордоо	ш	2830	
7	Тарилт	ш	2830	
8	Модны суулгац	ш	2830	
9	Чийг баригч	ш	2830	
10	Хашаа	га	2	
Мод суулгах, дагалдах хэрэгсэл угсралтын ажил				
1	Тухайн бүс нутагт ургах боломжтой мод суулгах	ш	2830	MNS 6139:2010, MNS 6140:2010
2	Суулгасан мод тус бүрт био ялзмаг, усалгаа хийх.	ш	2830	
3	Суулгасан мод, бут орчмын талбайг цэвэрлэх	2	га	
4	Усалгааны системийг ажилд залгах	ш	2830	
5	Хүлээлгэн өгөх	ш	2830	

ТӨСЛИЙН БАЙРШИЛ:

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих газрын кадастрын зураг



Мод тарих газрын тойм зураг



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ:



МОНГОЛ УЛС

ОЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН
ГЭРЧИЛГЭЭ

20 22 оны 05 дугаар сарын 02 ны өдөр

Улаанбаатар хот

Сөрөг: УБ. Дугаар 0220688

УЛААНБААТАР (аймаг, нийслэлийн) БАЯНГОЛ

(сум, дүүрэг)-ийн 5928869 тоот регистрийн дугаартай

ЧАНДМАНЬ ХАРХИРАА ХХК
(с/х зүйл эзлэж, байгууллага)

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 20 22 оны 05 сарын

25 өдрийн A/177 тоот тушаалын үндэстэн:

МОД ҮРЖҮҮЛЭХ, ОЙЖУУЛАХ, ОЙГ НӨХӨН СЭРГЭЭХ

чилгээгээр үйл ажиллагаа явуулах эрхийг ГУРВАН жилийн хугацаагаар олгоо.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Б.БАТ-ЭРДЭНЭ

Банди А.ЮУН-ЧИМЭГ
Чандмань Хархираа ХХК
Замаргаа
Гүйцэтгэх зөвшөөрөл



МОНГОЛ УЛС
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

20 21 авг 12
сарын 12 өдөр Дугаар 2021/155 Улаанбаатар хот

Эрх зүйн үйлчилгээний төрөл Жимс, жимсгэнэий суулгац үйлдвэрлэх

Тусгай зөвшөөрлийн нэр "Чандмань хархираа" ХХК

Аж: Увс аймгийн Улаангом сумын төвд

Тусгай зөвшөөрлийн хугацаа дөрвөн жил 2021.12.03 – 2024.12.03

Тусгай нотлох баримт

1. Монгол Улсад нутагшсан босон ирээдүйтэй сортоор батлагдсан жимс, жимсгэнэ суулгац үйлдвэрлэх.
2. Үргэлжсэн суулгацагт харилцарын хяналтад бүрэн хамруулах.
3. Чанар-стандартын шалдлага хангасан, гарал үүсэл, үйлдвэрлэсэн арга-технологийг баталгаажсан суулгац үйлдвэрлэх.
4. Жил бүр үргэлжлийн талбайд сортын хяналт баталгааг хугацаанд нь тогтмол хийлгэх.
5. Эрдэм шинжилгээний байгууллага, ХААДС-тай гэрээ байгуулж хамтран ажиллах.
6. Үйлдвэрлэсэн суулгацын тоо хэмжээг, зөрсүүлсэн зардалын мэдээ тайланг жил бүр гаргаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ирүүлэх.

Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамдын

20 21 авг 12 сарын 03 өдрийн д.201 дугаар тушаалыг үндэслэн олгов.



САЙД Э. МЭНДСАЙХАН

АЖИЛЛАХ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ МЭДЭЭЛЭЛ

№	Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр
1	Гүйцэтгэх захирал Төслийн удирдагч	Банди Ариунчимэг	Бизнесийн ухааны магистр Санхүүч	30 жил	7 жил, Компанийн үндсэн ажилтан
2	Ерөнхий менежер	Үймэгдэй Зоригтбаатар	Төрийн удирдлагын магистр	30 жил	7 жил, Компанийн үндсэн ажилтан
3	Төслийн менежер	Нацаг Буянжаргал	Үйлдвэрлэлийн менежер баклавар	20 жил	1 жил, Компанийн үндсэн ажилтан
4	Барилгын инженер	Зоригтбаатар Намуундарь	Иргэний барилгын инженер магистр	2 жил	2 жил, Компанийн үндсэн ажилтан
5	Агрономч	Пүрэв Оюунгэрэл	Ховд аймгийн Хөдөө аж ахуйн техникумын төгсөгч Агротехникч, агрономч	34 жил	3 жил, Компанийн үндсэн ажилтан
6	Ойн инженер	Баатаржав Баярхүү	Улаанбаатар дээд сургуулийн төгсөгч Ойжуулалт цэцэрлэгжүүлэлтийн инженер	12 жил	3 жил, Компанийн үндсэн ажилтан
7	Ойн инженер	Цэвээн Цэцэгбал	Хөдөө аж ахуйн их сургуулийн магистр Үхрийн нүдийг ногоон мөчрөөр үржүүлэх боломжийг судалсан	11 жил	3 жил, Гэрээт ажилтан
8	Ойжуулагч	Бямбаа Жавзмаа	Жимс ногоочин	25 жил	1 жил, Компанийн үндсэн ажилтан
9	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	Сүхбаатар Бат-Эрдэнэ	OSHAcademy, АНУ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн	11 жил	3 жил, Гэрээт ажилтан
10	Цахилгааны инженер	Мягмаржав Золзаяа	Барилгын коллежийн төгсөгч Цахилгааны инженер	21 жил	3 жил, Гэрээт ажилтан

АЖИЛЛАХ ГҮЙЦЭТГЭСЭН ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, БАГАЖ ХЭРЭГСЭЛИЙН
МЭДЭЭЛЭЛ

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	[“Өөрийн эзэмшил” эсхүл “түрээс” аль нэгийг бичих]
1	Ачааны автомашин	13,7 тн	1	Өөрийн
2	Ачааны автомашин	2,0 тн	1	Өөрийн
3	Усны машин	5,0 тн	1	Түрээсийн
4	Трактор иж бүрэн	25 морины хүчтэй	1	Өөрийн
5	Нүх ухагч	Өөр дээрээ мотортой	2	Өөрийн
6	Усалгааны системд угсарах тусгай зориулалтын багаж	ком	1	Өөрийн
7	Бусад (хүрз, жоотуу, тармуур, хувин, хэмжих метр, шороо зөөх тэрэг гэх мэт)	ком	1-8	Өөрийн

НОГООН ЗУРВАСЫН ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Ногоон зурвасын ажлын ажлыг дараах үе шатны хуваариар хийж гүйцэтгэлээ.

1. Бэлтгэл ажил - 06 сарын 01 - 06 сарын 17-ний хооронд
2. Үндсэн ажил - 06 сарын 10 - 06 сарын 28-ний хооронд
3. Ажлын тайлан - 06 сарын 28 - 07 сарын 01 ний хооронд

1. БЭЛТГЭЛ АЖЛЫН ТАЛААР

- 1.1. Ойжуулалт хийх газрыг судлах ойжуулах талбайн байршил эргэлтийн цэгийг тогтоох ажлыг Дундговь аймгийн Сайнцагаан сумын ЗДТГ, ойн ангиар үйлдүүлэх ажил хийгдсэн.
 - Дундговь аймгийн Сайнцагаан сумын засаг даргын тамгын газарт 40/24 тоот албан бичгийг өгч ойн зурваст ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэн. Албан хүсэлтийн дагуу засаг дарга “Нэгж талбарын хил, заагийн газарт бэхэлсэн эргэлтийн цэгийг хүлээлгэн өгсөн тухай акт үйлдэж, Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг Даргын Тамгын Газар /9033556/ -ын эзэмшиж байгаа газрын байршлыг тогтоож Төгс Ланд Сурвэй ХХК-иар байршилын координат ажил гүйцэтгэх газрын байршилын зургыг баталгаажуулж авав./ “Нэгж талбарын хил, заагийн газарт бэхэлсэн эргэлтийн цэгийг хүлээлгэн өгсөн тухай акт, газрын байршилын зургыг хавсралтаар/
- 1.2. Ойжуулалтын ажилд ажиллах ажилтнуудад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа өгч ажилтан тус бүрийг хөдөлмөр хамгаалалын хамгаалах хэрэгсэлээр хангаж ажилласан..
- 1.3. Ойжуулалтын ажилд ашиглах шинэ тоног төхөөрөмжүүд дээр ажиллах сургалтанд ажилчдыг хамруулж дадлагажуулав.
- 1.4. Ногоон зурвас байгуулах талбайн эргэлийн цэгийн дагуу 600м хамгаалалтын торон хашааг байгуулав. /Хамгаалалтын хашааны зургыг хавсаргав/
- 1.5. Ногоон зурвас байгуулах 2 га газарт цэвэрлэгээ хийж хээрийн хог хаягдал болох 10 тн хогыг ачиж зайлуулсан ба ойжуулах газрыг бүрэн боловсруулалт хийж бэлдэв.
- 1.6. Төслийн ажлын хүрээнд ойжуулах талбайн байнгын усалгааны системтэй байлгах зорилгоор тооцож гүн өрөмдлөг бүхий инженерийн хийцтэй гүний худаг байгуулав.
 - Гүний худаг өрөмдлөгийн ажлыг “Эхний эхэн” ХХК-тай хамтран ажиллаж гүйцэтгүүлсэн бөгөөд Дундговь аймгийн Сайнцагаан

сумын 5-р багийн нутаг дэвсгэрт 144 метр гүн өрөмдлөгтэй инженерийн хийцтэй худаг гаргав.

Худгын ус татах хатуу хоолой 150 м, худгийн ус татах насос 1 ш /1,5 квт хүчин чадалтай/ 150м цахилгааны утас, 150м тросын хамт угсарч байршуулав.
/Ажлын явцын зургыг хавсралтаар үйлдэв/;

➤ “Чандмань хархираа” ХХК-ийн барилгын хэсгийн ажилтнууд 6 мкв бүхий /3м*2М бүхий харьцаатай/ худгын байгууламж барьж будаж тохижуулав.

- 1.7. Усалгааны системд ашиглах усны нөөцийн сав /20тн бүхий ёмкост /-ыг Улаанбаатар хотоос тээвэрлэн блокоор тулгуур хийж байршуулав.
- 1.8. Ногоон зурвас 2га талбайг услах иж бүрэн дуслын услалтын системийг татаж байршуулав./Үүнд: Усалгааны дуслын системийн 2850 ш хошуу угсарч тавив, Усалгааны дуслын нарийн хоолой 16ф -тай 6000м, Усалгааны дуслын хоолой 50Ф-тай 300 м, хогны шүүгч шүүр 1ш, Ерөнхий коллекторт 50ф-тай 3ш хаалт угсарч тус тус байршуулав / Ажлын зургыг хавсралтаар/
- 1.9. Ногоон зурвас хэсэгт мод тарих техинлогийн картны дагуу 2850ш модны нүх ухаж бэлдэв.
- 1.10. Ногоон зурваст суулгах 2850 суулгацад зориулж 30 тн хар шороон хөрс татаж бэлдэв.
- 1.11. Ногоон зурваст суулгах суулгацын тоогоор био ялзмаг бордоо, чийг баригчийг бэлдэв.
- 1.12. Ойжуулсан талбайд мал бэлчээхийг хориглосон анхааруулах 6 ш тэмдэгтийг байршуулсан
- 1.13. Ойжуулсан талбайд нэвтэрэх хаалга хийсэн.
- 1.14. Ойжуулсан талбайн ажлын зорилго агуулсан мөн захиалгач, гүйцэтгэгчийн нэр бүхий агуулгатай мэдээлэлийн самбар байршуулсан.

2. ҮНДСЭН АЖЛЫН ТАЛААР

Ногоон зурвасын ажлын хуваарийн дагуу үндсэн хэсгийн ажлыг 2024 оны 06 сарын 10-ний өдрөөс 2024 оны 06 сарын 28-ний хооронд хийж гүйцэтгэв.

Мод тарилтын ажил гүйцэтгэсэн технолгын карт

- Ногоон зурвасын схемийн дагуу 2 га газарт 2850 ширхэг стандартын 1,2-р зэргийн 3-4 настай навчит модны суулгацыг мөр хооронд 4м, ургамал хооронд 3 м байхаар тооцож төсөвийн дагуу хайлаас -2000ш, улиас 850 ширхэг нийт 2850 ширхэг навчит мод тарьж гүйцэтгэв.
- Нүхний хэмжээг 0,6х0,7 нүх ухаж суулгац тарихад бэлэн болгов.
- Ногоон зурваст суулгах суулгац бүрийн доор чийг баригчийг суулгав.
- Суулгацын үндэсийг нугалахгүйгээр тараан байрлуулж нүхнээс гарсан үндсэн хөрсөөр тодорхой түвшинд байхаар шороогоор дүүргэж хонины ноосон бордооны био ялзмагтай субетрит бэлдэн хольж тарилтыг хийлээ.
Ухсан нүхэнд хар шороо, элс бууцны холимоогоор /Суулгац тарих MNS6139 : 2010, стандартын 2,7-д заасны дагуу нэг нүхэнд орох тусгайлан бэлтгэсэн холимог, хар шороон хөрсний хэмжээг тооцов / дүүргэлт хийж өгсөн.
- Ногоон зурваст суулгасан модыг дуслын усалгааны системээр байнга усалж байгаа бөгөөд услах явцад шувууны исгэсэн сангас бордоогоор бордож модны хөрсийг баяжуулж байна.
- Суулгацыг суулгасанаас хойш 15 хоногын дараа ургамал хамгаалалтын бодис цацаж хорхой, шавьжнаас хамгаалав.

НОГООН ЗУРВАС АЖЛЫН ТАЙЛАНГЫН ДҮГНЭЛТ

Монгол Улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн №58 тоот зарлиг, МУ-ын засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/218 тоот тушаалийн хэрэгжилтийг хангаж Эрчим хүчний салбарын хэмжээнд ногоон хэрэм байгуулах ажлын хүрээнд Дундговь аймагт үе шаттайгаар нэг зуун мянган мод тарих ажлыг хэрэгжүүлэх хүрээнд хөрсний элэгдэл, элсний нүүлтийг зогсоох ногоон зурвас байгуулах ажилд гүйцэтгэгчээр сонгогдож ДЦС-3 ТӨХК-тай 2-3-276/24 тоот “Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих ажлын гэрээ” байгуулан ажиллаж байна.

Гэрээт ажлыг Дундговь аймгийн Сайнцагаан сумын 5-р багийн нутаг дэвсгэрт байрлах 2 га талбайд 2024 оны 06 сарын 01 ний өдрөөс 2024 оны 07 сарын 01-ний хооронд ажлын хуваарийн дагуу бүрэн хийж гүйцэтгэлээ.

- “Чандмань хархираа” ХХК нь тус гэрээт ажлыг 10 хүний бүрэлдэхүүнтэй 7 төрлийн техник хэрэгсэл, багаж хэрэгсэлээр ойн зурвасын ажлын үе шат, батлагдсан технологиин картны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөрчилгүй хийж гүйцэтгэсэн.
- Ойжуулалт хийх газрыг судлах, ойжуулах талбайн байршил эргэлтийн цэгийг тогтоох ажлыг Дундговь аймгийн Сайнцагаан сумын ЗДТГ, ойн ангиар үйлдүүлэх ажил хийгдсэн.
- Ногоон зурвас байгуулах талбайн эргэлийн цэгийн дагуу 600м хамгаалалтын торон хашааг байгуулав.
- Ногоон зурвас байгуулах 2 га газарт цэвэрлэгээ хийж хээрийн хог хаягдал болох 10 тн хогыг ачиж зайлуулсан ба ойжуулах газрыг бүрэн боловсруулалт хийж бэлдэв.
- Төслийн ажлын хүрээнд ойжуулах талбайн байнгын усалгааны системтэй байлгах зорилгоор тооцож гүн өрөмдлөг бүхий инженерийн хийцтэй гүний худаг байгуулав.
- Ногоон зурвас 2га талбайг услах иж бүрэн дуслын услалтын системийг татаж байршуулав.
- Ногоон зурвасын схемийн дагуу 2 га газарт 2850 ширхэг стандартын 1,2-р зэргийн 3-4 настай навчит модны суулгацыг мөр хооронд 4м, ургамал хооронд 3 м байхаар тооцож төсөвийн дагуу хайлаас - 2000ш, улиас 850 ширхэг нийт 2850 ширхэг навчит мод тарьж гүйцэтгэв
- Суулгацыг суулгасанаас хойш 15 хоногын дараа ургамал хамгаалалтын бодис цацаж хорхой, шавьжнаас хамгаалав

Манай компани цаашид гэрээний дагуу ойн зурваст суулгасан суулгацад 3 жилийн хугацаанд арчилгаа, нөхөн тарилтын ажлыг бүрэн хариуцаж ажиллах болно.

Ногоон зурвас байгуулах 2 га газарт “Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих ажлыг чанарын өндөр түвшинд 100 хувийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэсэн гэж дүгнэж байна

Тайлан бичсэн:

“ЧАНДМАНЬ ХАРХИРАА” ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.АРИУНЧИМЭГ

“ЭХНИЙ ЭХЭН” ХХК
Улаанбаатар, Баянзүрх, 15-р хороо
13-р хороолол 72-57 тоот
Утас: +976 9919 3679
2024.07.04 № 103
танай _____ № _____ -т

ДЦС-3 ТӨХКОМПАНИЙ ЗАХИРГААНД

Тодорхойлолт гаргах тухай

Манай компани “Чандмань Хархираа” ХХКомпанитай харилцан тохиролож Дундговь аймгийн Сайнцагаан сумын 5-р багийн нутаг дэвсгэрт 144 метр гүн өрөмдлөгөтэй инженерийн хийцтэй худаг гаргаж өгсөн нь үнэн болно.

ХҮНДЭТГЭСЭН:

ЗАХИРАЛ



О.ХҮҮХЭНБААТАР

Мод тариалалт.




Зарим нэр төрлийн багаж, усны шахах насос.



Хамгаалалтын 600 м торон хашаа байгуулав.



Хамгаалалтын 600 м торон хашаа байгуулав.




Усны нөөц үүсгэх зориулалттай усны нөөцийн сав
байршуулав /20тн/.



Хонины ноосон бордоог тариалалтад ашиглав.



Хонины ноосон бордоог тариалалтад ашиглав.



**Гүн өрөмдлөг бүхий инженерийн
хийцтэй гүний худаг байгуулав**



Ойжуулалт хийсэн талбайн ерөнхий зураглал



**“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ШИНЭ
НАЛАЙХ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНД “ДЦС-3” ТӨХК-ААС
2024 ОНЫ НАМАР МОД ТАРЬСАН АЖЛЫН ТАЙЛАН**

	ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ	АШБ-ТБХ-09-2015
		Хувилбар 1

БАТЛАВ
“ДЦС-3” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Л.ЭРХБААТАР

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН САНААЧИЛСАН “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ
ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД НАЛАЙХ ДҮҮРГИЙН ШИНЭ НАЛАЙХ ЦЭЦЭРЛЭГТ
ХҮРЭЭЛЭНД МОД ТАРИХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2024.10.01

Хугацаа: 2024 оны 10 дугаар сарын 06-ны өдөр

Оролцогчид: Эрчим хүчний яам болон Улаанбаатар хотын дулааны цахилгаан станцууд

Хаана: Улаанбаатар хотын налайх дүүрэг “Шинэ налайх цэцэрлэгт хүрээлэн”

Зорилго: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум Мод” үндэсний хөдөлгөөнийг үндэслэн байгалийн тэнцвэрт байдлыг хадгалах, цөлжилт, газрын доройтолтой тэмцэх ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Эрчим хүчний салбарын Улаанбаатар хотын 11 байгууллага мод тарих ажилд оролцоно.

Хугацаа	Үйл ажиллагаа
09:45	<ul style="list-style-type: none">“ДЦС-3” ТӨХК Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа авч налайх дүүрэг рүү хөдөлнө.
	Бэлтгэл ажил
12:30-13:00	<ul style="list-style-type: none">Налайх дүүргийн шинэ налайх цэцэрлэгт хүрээлэнд мод тарих байршил, суулгацыг авч мод тарих бэлтгэл ажил хангана.
	Мод тарих
13:00-14:00	<ul style="list-style-type: none">“ДЦС-3” ТӨХК-ийн ажилтнууд хуваарьт талбайд технологийн дагуу гацуур, хус мод суулгаж усалгаа хийнэ.
	Ажлын хэсэгт хүлээлгэн өгөх
14:00-14:30	<ul style="list-style-type: none">Налайх дүүргийн холбогдох албаны хүмүүст тарьсан модыг хүлээлгэн өгч мод тарих ажлыг дуусгана.
	Хаалт
15:00	<ul style="list-style-type: none">Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнгээс “ДЦС-3” ТӨХК- руу буцна.

Хянасан:

Захиргаа хүний нөөцийн албаны дарга

Э.Мөнхшүр

Төлөвлөгөө гаргасан:

Үйлдвэрлэлийн экологийн инженер

Э.Энхбат





“ДЦС-3” ТӨХК-ийн эзэмшил газарт мод тарилтын ажил

2024 он

71 ш навчит модны оронд 71 ш шилмүүст мод тарьсан.

Тарилт хийгдсэн модны мэдээлэл

Модны нэр	Хэмжээ
Тарилт хийгдсэн модны төрөл	Гацуур
Модны ширхэг	71
Модны нас	9
Модны өндөр	0.5-0.8 м
Бусад тэмдэглэл /мод бэлтгэсэн газар/	Баянзүрх дүүрэг, 10 хороо, улиастай, 16 хэсэг
Мод тарьсан газрын байршил	ДЦС-3 ТӨХК-ний хашаан дотор
Тарилт хийгдсэн өдөр	2024.05.27-28

Тарилт хийгдсэн модны байршил

Тарилт хийгдсэн модны фото



 <p>2024 оны 5-р сарын 28 11:46:40 ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>	 <p>2024 оны 5-р сарын 28 11:00:00 ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>	 <p>2024 оны 5-р сарын 28 10:27:48 ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>	 <p>2024 оны 5-р сарын 28 10:54:00 ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>
 <p>2024 оны 5-р сарын 28 10:11:23 ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>	 <p>2024 оны 5-р сарын 28 10:18:02 ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>	 <p>2024 оны 5-р сарын 28 10:13:00 ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>	 <p>2024 оны 5-р сарын 28 09:41:42 ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>
 <p>2024 5-р сарын 28 09:53:57</p>	 <p>2024 оны 5-р сарын 27 16:26:00 ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>	 <p>2024 оны 5-р сарын 27 16:28:32 17070 Үйлдвэрийн гудамж ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>	 <p>2024 оны 5-р сарын 27 14:13:23 ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>
 <p>2024 оны 5-р сарын 27 14:41:59 ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>	 <p>2024 оны 5-р сарын 27 14:41:59 ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>	 <p>2024 оны 5-р сарын 28 09:32:05 ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>	 <p>2024 оны 5-р сарын 27 16:17:09 17070 Үйлдвэрийн гудамж ХУД - 3 хороо Хан-Уул Дүүрэг Улаанбаатар Ти Жэй Эн форестри ХХК</p>

Зураг тарилт хийж байх үеийн фото, ДЦС-3



Модны ургалтын өнөөгийн байдал, ДЦС-3







БАТЛАВ.
 “ДЦС-3” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
 Л. ЭРХБААТАР



2024 ОНД ЦЕХ, ХЭСГҮҮДЭД ХИЙГДЭХ АЖЛЫН БАЙРНЫ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ
 НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.01.09

д/д	Эрсдэлийн үнэлгээ хийх ажлын байр, ажилбарын нэр	Үнэлгээ хийх хугацаа	Хариуцах ажилтан	Хамтран хэрэгжүүлэх ажилтан	Гүйцэтгэлийн хэмжүүр
Түлш дамжуулах цех					
1	Туузан дамжлага ЛК-5 ажлын байрны шат тавцангаар зорчих эрсдэлийн үнэлгээ	1,2-р сар	ТД цех хариуцсан ХАБ-н инженер Н.Нарангэрэл	ТДЦехийн эрсдэлийн үнэлгээний баг	Хийгдсэн
2	Дагон хөмрөгч Б-н ДФМ-ийн тавцанд ажиллах, рещётка цэвэрлэх үеийн эрсдэлийн үнэлгээ	1,2-р сар			80%
3	Туузан дамжлага ЛК-7-н хаягдлын болон уурын шугамуудын тулгуур багануудын эрсдэлийн үнэлгээ	2,3-р сар			Хийгдсэн
Дунд даралтын зуухан цех					
1	Зуух №1-н уур хөргөгчийн зүрхэвч суглаж засварлах үеийн эрсдэлийн үнэлгээ	II улирал	ДДЗ цех хариуцсан ХАБ-н инженер М.Батсайхан	ДДЗ цехийн эрсдэлийн үнэлгээний баг	80%
2	Тоосон системийн тоноглолын люк тагнуудад эрсдэлийн үнэлгээ	II улирал			80%
3	Хоёрдогч агаарын хоолойнуудын люк тагнуудад эрсдэлийн үнэлгээ хийх	III улирал			80%
4	Зуухны галын хотолд элс хийх үеийн эрсдэлийн үнэлгээ	III улирал			Хийгдсэн
Дунд даралтын турбин цех					
1	Бойлерын машинчийн ажлын байранд ажил гүйцэтгэх үеийн эрсдэлийн үнэлгээ	I улирал	ӨДТ болон ДДТ цех хариуцсан ХАБ-н инженер А.Хандмаа	ДДТ цехийн эрсдэлийн үнэлгээний баг	Хийгдсэн
2	Тэжээлийн усны насосны машинчийн ажлын байранд ажил гүйцэтгэх үеийн эрсдэлийн үнэлгээ	II улирал			Хийгдсэн
3	Цехийн барилга байгууламжийн гадна аваарийн шатанд эрсдэлийг арилгах	III улирал			80%
Өндөр даралтын турбин цех					
1	ЦП(худгийн дренаж) -5,6 руу буух, цирк систем таслах, залгах үеийн эрсдэлийн үнэлгээ	I улирал	ӨДТ болон ДДТ цех хариуцсан	ӨДТ цехийн эрсдэлийн	80%



2	Насос станцын 1000м3 ус нөөцлүүр бакад цэвэрлэгээ хийх үеийн эрсдэлийн үнэлгээ	II улирал	ХАБ-н инженер А.Хандмаа	үнэлгээний баг	<i>Хийгдсэн</i>
Өндөр даралтын зуухан цех					
1	МАН-н конденсатын бак ажиллагаанд залгах, таслах үеийн эрсдэлийн үнэлгээ	II улирал	ӨДЗ цех хариуцсан ХАБ-н инженер Ш.Түвшинтөгс	ӨДЗ цехийн эрсдэлийн үнэлгээний баг	<i>Хийгдсэн</i>
2	Авто кранаар ачаа өргөж, зөөх үеийн эрсдэлийн үнэлгээ	III улирал			<i>90%</i>
3	Шнек ваннаас шлакны сорьц авах үеийн эрсдэлийн үнэлгээ	III улирал			<i>80%</i>
4	Зуух №11-н шат тавцан, гэрэлтүүлэг, тоноглолын эрсдэлийн үнэлгээ	IV улирал			<i>Хийгдсэн</i>
Цахилгаан цех					
1	ӨДХ ба ДДХ-ийн ХХБ дахь 0.4кВ-ийн тоноглолын оруулга тайлах, холбох үеийн эрсдэлийн үнэлгээ	I-IV улирал	Цахилгаан цех хариуцсан ХАБ-н инженер Ж.Мөнх-Эрдэнэ	Цахилгаан цехийн эрсдэлийн үнэлгээний баг	<i>90%</i>
2	Турбогенератор №5-8 шиний мостны эрсдэлийн үнэлгээ	III улирал			<i>80%</i>
3	ӨДХ-ийн аккумуляторын байгууламжинд ажил гүйцэтгэх	IV улирал			<i>80%</i>
Дулааны хянах хэмжүүр автоматикийн цех					
1	Зуух №8-н тээрмийн өмнөх холимогийн температурын анхдагч хэмжигч хэрэгсэл	II улирал	ДХХА цех хариуцсан ХАБ-н инженер Ө.Мөнгөнцэцэг	ДХХА цехийн эрсдэлийн үнэлгээний баг	<i>90%</i>
2	Зуух №9-н хурц уурын температурын анхдагч хэмжигч хэрэгсэл	III улирал			<i>80%</i>
Засварын цех					
1	ӨДЗ болон ДДЗ цехийн үнсний шугамд засвар хийх	I-IV улирал	Засварын цех хариуцсан ХАБ-н инженер П.Маргад-Эрдэнэ	Засварын цехийн эрсдэлийн үнэлгээний баг	<i>80%</i>
2	ӨДТ цехийн ЦЭН-5,6 руу шатаар буух үеийн эрсдэлийн үнэлгээ	I-IV улирал			<i>50%</i>
3	Зуух №7-13-н хооронд ▼9,6 тэмдэгт дээрх үзлэгийн люк засварлах	I-IV улирал			<i>30%</i>
4	ӨДЗ цех өрлөг дулаалгын материал хураах складанд ажиллах үеийн эрсдэлийн үнэлгээ	I-IV улирал			<i>50%</i>
5	Зуух №7-н тоос хуваарилагч клапан №1-6-д засвар хийх	I-IV улирал			<i>50%</i>
6	ӨДТ цехийн ТГ№5-н ПНД-1,2,3-н шат тавцан дээр ажиллах	I-IV улирал			<i>100%</i>
7	Химийн бодисын агуулахад ажиллах үеийн эрсдэлийн үнэлгээ	I-IV улирал			<i>80%</i>



8	ӨДЗ цехийн тээрмийн болон үлээх салхилуурын эгнээнд галын усны шугам хоолой, хаалт арматурт засвар хийх	I-IV улирал			80%
9	ДДЗ цехийн ДВ№3-н цахилгаан хөдөлгүүрт засвар хийх	I-IV улирал			30%
10	Туузан дамжлага ЛК-7-д ажиллах үеийн эрсдэлийн үнэлгээ	I-IV улирал			100%
Хими цех					
1	Химийн бодисын агуулахын эрсдэлийн үнэлгээ	I улирал	Хими цех хариуцсан ХАБ-н инженер М.Нургуль	Хими цехийн эрсдэлийн үнэлгээний баг	80%
2	ӨДХУБ-ийн фильтр заалны эрсдэлийн үнэлгээ	I улирал			85%
Механик цех					
1	Сэндвичэн байрны үзэлийг өргөтгөх ажил	1-р сард	Механик цех хариуцсан ХАБ-н инженер Д.Равжих	Механик цехийн эрсдэлийн үнэлгээний баг	80%
2	Хүчилтөрөгч аж ахуйн баллоны тавцангийн зорчих хэсгийг сайжруулах	1-р сард			100%
3	ӨДЗ цехийн утаа сорогчийн гүүрэн краны зам дагуух зорчих хэсгийг сайжруулах	1-р сард			70%
Уурын хэсэг					
1	ҮУШС-ний 1501-р цэгт эрсдэлийн үнэлгээ хийх	I улирал	Уурын хэсгийн мастер Э.Тод-Эрдэнэ	Уурын хэсгийн эрсдэлийн үнэлгээний баг	Хийгдсэн
2	ҮУШС-ний Арьс ширний чиглэлийн салбар шугамын төгсгөлийн дулааны худагт эрсдэлийн үнэлгээ хийх	II улирал			Хийгдсэн
3	ҮУШС-ний Модон завод чиглэлийн салбар шугамын төгсгөлийн дулааны худагт эрсдэлийн үнэлгээ хийх	III улирал			Хийгдсэн.
4	ҮУШС-ний Баруун чиглэлийн чиглэлийн салбар ерөнхий таслах хаалтны шат тавцанд эрсдэлийн үнэлгээ хийх	IV улирал			80%

ТАНИЛЦСАН: ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Н.ЧИМЭДДОРЖ

ХЯНАСАН: ДОТООД ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.МӨНХ-ЭРДЭНЭ

ТӨЛӨВЛӨГӨӨ НЭГТГЭН ГАРГАСАН:

ХАБ ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

Б.НАРАНЦАЦРАЛ



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ДХХ-50-2022

Хувилбар 2

2024 ОНЫ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

2024.09.01

№	Хийгдэх ажлууд	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэгч	Гүйцэтгэл
Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар					
1	2024 онд ISO 45001:2018 “ХЭМАБ”-ын менежментийн тогтолцоо - ISO 45001:2018 стандартыг бүх түвшинд хэрэгжүүлж ажиллах	Жилдээ э	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	ДХХ-ийн дарга Ж.Мөнх-Эрдэнэ Ахлах инженер Н.Бямбадорж	Хэрэгжүүлж ажиллаж байна
2	2024 онд ISO 45001:2018 “ХЭМАБ”-ын менежментийн тогтолцоо - ISO 45001:2018 стандартын баталгаажуулалт хийлгэж, гэрчилгээ авах	Жилдээ э	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	ДХХ-ийн дарга Ж.Мөнх-Эрдэнэ Ахлах инженер Н.Бямбадорж	Анхдагч баталгаажуулалтын 1 дэх шатны аудитыг “SFCS” компанийн ISO 45001:2018 стандартын тэргүүлэх аудитор Л.Эрдэнэбат, Ж.Дуламсүрэн нар хийсэн. 24 үзүүлэлтээс үл тохирол илрээгүй. 10 сайжруулах санал гарсан. Нэг шатны аудитын тайлан зөвлөмжийн дагуу сайжруулах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж, 2 шатны аудитыг хийлгэхэд бэлэн болоод байна.
3	2024 оны аюулгүй ажиллагааны зорилтын хүрээнд сар бүр зорилт тавьж, удирдамж боловсруулж, хяналтын хуудсаар хяналт шалгалт хийх	Жилдээ э	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	Цех хариуцсан ХАБ-н инженерүүд	Зорилтын дагуу удирдамж боловсруулж, сар бүр хяналтын хуудсаар шалгалт хийж, илэрсэн зөрчилд ДХХ -н албан шаардлага хүргүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал”, “Галын аюулгүй байдал”, 7 хоног, сар бүрийн мэдээ тайланг цаг	Жилдээ э	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	Цех хариуцсан ХАБ-н инженерүүд	Сар бүр хийгдэж байна.



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ДХХ-50-2022

Хувилбар 2

	тухайд нь гаргаж, ЭХЯ-ны сайтад байршуулан, Гүйцэтгэх захиралд танилцуулах				
Хоёр. ХАБ-ын журам, зааврын боловсруулалт, мөрдөлт, хэрэгжилтийн талаар					
5	“ХАБЭА”-н хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дах хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийн үйл ажиллагааны чиг үүргийг эрчимжүүлэх	Жилдэ э	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	ДХХ-ийн дарга Ж.Мөнх-Эрдэнэ Ахлах инженер Н.Бямбадорж	Чиг үүргийн дагуу зөвлөл ажиллаж байна.
6	“ХАБЭА”-н шаардлагатай журам, зааврыг стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулж хэрэгжүүлэх.	Жилдэ э	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	ДХХ-ийн дарга Ж.Мөнх-Эрдэнэ Ахлах инженер Н.Бямбадорж	ХАБЭА-н журам, заавруудыг шинэчлэн боловсруулж байна.
7	Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн чанар, норм стандарт, олголт, зохистой хэрэглээнд хяналт тавих	Жилдэ э	ХАБ хяналтын инженер С.Болормаа Б.Наранцацрал	ХАБЭА-н орон тооны бус зөвлөл	Хяналт тавьж ажиллаж байна.
8	ХАБЭА”-н хууль, дүрэм, журам, зааврын хэрэгжүүлэлтийн байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах	Жилдэ э	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	Цех хариуцсан ХАБ-н инженерүүд	Зөрчлүүдэд албан шаардлага, мэдэгдэл хүргүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.
Гурав. Аюулгүй ажиллагааг хангаж ажиллах талаар					
9	ХАБЭА-н III шатны үзлэгийн жилийн төлөвлөгөөг гаргаж, улирал бүр үзлэгийн удирдамж, хөтөлбөр боловсруулж, үзлэгийг зохион байгуулах	Улирал бүр	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех, хэсгийн дарга нар, цех хариуцсан ХАБ-н инженерүүд	Эхний 3 улирлын н III шатны үзлэгийн удирдамж, хөтөлбөр боловсруулж, үзлэгийг зохион байгуулсан.



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ДХХ-50-2022

Хувилбар 2

10	ХАБЭА-н I, II шатны үзлэгт хяналт тавьж, чанарыг сайжруулах	Тогтмол	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех хариуцсан ХАБ-н инженерүүд	ХАБЭА-н I, II шатны үзлэгийг өдөр бүр хяналт тавьж ажиллаж байна.
11	Наряд, ам шийдвэрээр гүйцэтгэж байгаа ажлын аюулгүй байдлыг хариуцагч нарыг гүйцэтгэх захирлын тушаалаар томилж ажиллуулах. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	Тогтмол	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех, хэсгийн дарга нар, цех хариуцсан ХАБ-н инженерүүд	Аюулгүй байдлыг хариуцагч нарыг гүйцэтгэх захирлын тушаалаар томилж, өөрчлөлт орсон тухай бүр нь шинэчлэн батлуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.
12	Станцын хэмжээнд наряд, ам шийдвэрээр хийгдэх ажлын нэгдсэн жагсаалтыг гаргаж, Гүйцэтгэх захирлаар батлуулж, мөрдөлтөд хяналт тавих	01-р сард тогтмол	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех, хэсгийн дарга нар, цех хариуцсан ХАБ-н инженерүүд	Наряд, ам шийдвэрээр хийгдэх ажлын нэгдсэн жагсаалтыг гаргаж, Гүйцэтгэх захирлаар батлуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.
13	"Цоож, пайзны системийг хэрэглэх журам"-ыг шинэчлэн гаргаж, баталгаажуулж ажиллах	3-р улиралд	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех хэсгийн дарга нар, цех хариуцсан ХАБ-н инженерүүд	Хийгдэж байна.
14	Станцын хэмжээнд "Цоож пайзны системийг хэрэглэх журам"-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Жилдээ	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех хариуцсан ХАБ-н инженерүүд	Хяналт тавьж ажиллаж байна.
Дөрөв. ХАБ-ын шат, шатны зааварчилгаа, сургалт, шалгалт, эрсдэлийн талаар					
15	Шат, шатны аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллах. Зааварчилгааг ажилтанд өгч баталгаажуулсан байдалд хяналт тавьж ажиллах	Тогтмол 1-р улиралд	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	Цех, хэсгийн дарга нар, цех хариуцсан ХАБ-н инженерүүд	Эхний 8 сарын байдлаар: <ul style="list-style-type: none">▪ урьдчилан зааварчилгаа – 1309▪ анхан шатны зааварчилгаа – 503▪ Өдөр тутмын зааварчилгаа – 87674▪ Давтан зааварчилгаа – 7174▪ Ээлжит бус зааварчилгаа – 9915 Тухайлсан зааварчилгаа – 22750 өгөгдсөн



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ДХХ-50-2022

Хувилбар 2

					байна
16	Төлөвлөгөөний дагуу ажлын байруудад ажлын байрны эрсдэлийн үнэлгээг хийж эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулан, эрүүл, аюулгүй ажлын байрыг нэмэгдүүлэх	Төлөвлөгөөний дагуу	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	Цех хариуцсан ХАБ-н инженерүүд	40 ажил төлөвлөснөөс 32 ажил бүрэн хийгдсэн
17	Хувь хүний эрсдэлийн үнэлгээ TAKE 5 хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах	Тогтмол	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	Цех хариуцсан ХАБ-н инженерүүд	Эхний 8 сарын байдлаар: ▪ нийт бөглөгдсөн хуудсны тоо -11561 ▪ аюулыг мэдээлсэн хуудсны тоо – 696 ▪ устгасан аюулын тоо – 583 эрсдэлийг хяналтандаа авч ажлаа гүйцэтгэсэн хуудсны тоо - 11001
18	Шинэ ажилтныг чиглүүлэх сургалтын хөтөлбөр, сэдвийг сургалтын хэсэгтэй хамтарч боловсруулан батлуулж, батлагдсан сэдвийн дагуу сургалтыг тогтмол явуулах	Тогтмол	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	ЗХНА-ны сургалтын инженер	Батлагдсан сэдвийн дагуу сургалт явуулж байна.
19	ХАБЭА-н сургалт, эрсдэлтэй ажлын байрны сургалт болон аваарь, ослын үед анхны тусламж үзүүлэх сургалт дасгалыг төлөвлөгөөний дагуу нийт ажилтнуудад явуулах	Тогтмол	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	Цех хариуцсан ХАБ-н инженерүүд	Төлөвлөгөөний дагуу Өргөх зөөх механизмын ачаа шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцагч, аюулгүй ажиллагаа хариуцагч, сагст өргүүрийн оператор, оосорлогч дохиочны эрх олгох сургалтыг “Монкран консалтинг” ХХК-тай гэрээ байгуулан 2024 оны 04 дүгээр сарын 22-ноос 24-ний хооронд нийт 93 ажилтныг хамруулсан. 2024 оны сургалт хөгжлийн төлөвлөгөөний дагуу зуух, даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажилладаг ажилтнуудын эрх олгох сургалтыг “Хэрлэн эрдэс хими” ХХК-тай



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ДХХ-50-2022

Хувилбар 2

					гэрээ байгуулан 2024 оны 01 дүгээр сард засварын ажилтнуудад, 04 дүгээр сард ашиглалтын ажилтнуудад нийт 126 ажилтныг хамруулсан.
20	ААД, ТАД, ГАБД-ийн мэдлэгийн шалгалтыг графикийн дагуу бүх ИТА, ажилтнуудаас авах	10-р сард	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	ЗХНА-ны сургалтын инженер	Хуваарийн дагуу шалгалтыг авна.
21	Төлөвлөгөөний дагуу эрх бүхий байгууллагаар ажлын байрны нөхцөлийн үнэлгээг хийлгэж, зөвлөмжийн дагуу зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллах	Тогтмол	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	Эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан	Төлөвлөгөөний дагуу ажлаа гүйцэтгэж байна.
22	Цех, хэсэг, нэгжийн ажлын байрны температур, чийгшил, дуу шуугиан, гэрэлтүүлэг, тоосжилтыг хэмжиж, илэрсэн зөрчлийн мөрөөр холбогдох цех, хэсгүүдэд зөрчлийг арилгах албан мэдэгдлийг хүргүүлж хяналт тавьж ажиллах.	Тогтмол	ХАБ хяналтын инженер Б.Наранцацрал, С.Болормаа	Эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан	Ажлын байрны температур, чийгшил, дуу, шуугиан, гэрэлтүүлэг, тоосжилтын хэмжилтүүдийг улирал тутамд дотооддоо хийж ажлын байрны орчин зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлтийг хэмжиж зөрчлийг арилгуулах талаар зөвлөгөө зөвлөмж өгч ажиллаж байна.
Тав. Даралтат сав, шугам хоолойн аюулгүй байдлын талаар					
23	ЭХЯ-ны хяналтад хамаарагддаг буюу компанийн бүртгэл бүхий уурын зуух, даралтат сав, шугам хоолойнуудын бүрэн бүтэн байдлын аюулгүй ажиллагааг хариуцагч нарыг, Гүйцэтгэх захирлын тушаалаар томилж ажиллуулах. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж	1-р сард	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех, хэсгийн дарга, ахлах инженер, ашиглалт, засварын инженер, мастерууд, цех хариуцсан ХАБ-ын инженерүүд	Уурын зуух, даралтат сав, шугам хоолойнуудын бүрэн бүтэн байдлын аюулгүй ажиллагааг хариуцагч нарыг тушаалаар томилж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ДХХ-50-2022

Хувилбар 2

	ажиллах.				
24	Даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажилладаг ажилтнуудын эрх сунгах, шинээр авах сургалтыг тусгай зөвшөөрөл бүхий сургалтын компаниар хийлгэж, шалгалт авч, эрх олгуулах	2, 4-р сард	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех, хэсгийн дарга, ахлах инженер, ашиглалт, засварын инженер, мастерууд, цех хариуцсан ХАБ-ын инженерүүд	Зуух, даралтат сав, шугам хоолойтой харьцаж ажилладаг ажилтнуудын эрх олгох сургалтыг “Хэрлэн эрдэс хими” ХХК-тай гэрээ байгуулан 2024 оны 01 дүгээр сард засварын ажилтнуудад, 04 дүгээр сард ашиглалтын ажилтнуудад нийт 126 ажилтныг хамруулж, эрхийг сунгасан.
25	ЭХЯ-ны хяналтай даралт сав шугам хоолойн их засварын дараах туршилт, баталгаажилтад, байцаагчийн ажиллуулах зөвшөөрөл авсан эсэхэд хяналт тавьж ажиллах.	11-р сард	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех, хэсгийн дарга, ахлах инженер, ашиглалт, засварын инженер, мастерууд, цех хариуцсан ХАБ-ын инженерүүд	Хяналт тавьж ажиллаж байна.
26	Станцад ашиглагдаж байгаа даралтат сав, шугам хоолойд хяналтын хуудсаар үзлэг хийж, илэрсэн зөрчлийг ДХХ-ээс албан шаардлага өгч арилгуулах	Жилдэ э	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех хариуцсан ХАБ-ын инженерүүд	Хийгдэж байна.
Зургаа. Өргөх зөөх механизмын аюулгүй байдлын талаар					
27	“Өргөх зөөх механизмын ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн мөрдөлтөд тогтмол хяналт тавьж осол, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх	Тогтмол	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех, хэсгийн дарга, ахлах инженер, ашиглалт, засварын инженер, мастерууд, цех хариуцсан ХАБ-	Хяналт тавьж ажиллаж байна.



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ДХХ-50-2022

Хувилбар 2

				ын инженерүүд	
28	Кранаар ачаа өргөж шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаа хариуцагч нар, краны бүрэн бүтэн байдлыг хариуцагчийг тушаалаар томилох. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	1-р сард	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех, хэсгийн дарга, ахлах инженер, ашиглалт, засварын инженер, мастерууд, цех хариуцсан ХАБ-ын инженерүүд	Захирлын тушаалаар томилж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.
29	Цех хэсгүүдийн өргөх зөөх механизмтай харьцаж ажилладаг ажиллагсдаас "Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"-ийн шалгалт авч эрх сунгах.	1-р сард	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	ЗХНА-ны сургалтын инженер	Өргөх зөөх механизмын ачаа шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцагч, аюулгүй ажиллагаа хариуцагч, сагст өргүүрийн оператор, оосорлогч дохиочны эрх олгох сургалтыг "Монкран консалтинг" ХХК-тай гэрээ байгуулан 2024 оны 04 дүгээр сарын 22-ноос 24-ний хооронд нийт 93 ажилтныг хамруулж, эрх сунгасан.
30	Компанийн хэмжээнд ашиглагдаж байгаа өндөрт ажиллах хамгаалах бүсийг туршиж аюулгүй байдлыг хангуулах	2, 8-р сард	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех, хэсгийн дарга нар, ахлах инженер, ашиглалт, засварын инженер, мастерууд	Компанийн хэмжээнд ашиглагдаж байгаа өндөр ажиллах бүсийг графикайн дагуу өргөх зөөх механизмын мастер үзлэг хийхийн зэрэгцээ бүс ашиглах ажилтан хэрэглэхийг өмнө үзлэг хийж, бүртгэл хөтлөнө.
31	Ачаа өргөж шилжүүлэх үед ашиглагдаж байгаа гогцоо трос, ган татлага, гар таль зэргийг туршиж баталгаажуулах ажилд хяналт тавих. Цехүүдийн ачаа, хог зөөдөг яцикийг туршиж баталгаажуулж ашиглах, ажлыг	2, 8-р сард	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех хариуцсан ХАБ-ын инженерүүд	Графикайн дагуу туршилт хийж, ашиглалтанд хяналт тавьж байна.



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ДХХ-50-2022

Хувилбар 2

	аюулгүй гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавих.				
32	Гүүрэн кран, цахилгаан талиудын их, урсгал засварыг графикайн дагуу хийж байгаа эсэх, техникийн бичиг баримтад бичилт хийсэн эсэхэд хяналт тавьж ажиллах.	Графикайн дагуу	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех хариуцсан ХАБ-ын инженерүүд	Хяналт тавьж байна
33	Станцад ажил үүрэг гүйцэтгэж байгаа, гүүрэн кран, авто кран, сагст өргөгчид хяналтын хуудсаар ӨЗМ-ын аюулгүй байдалд үзлэг, шалгалт 2 удаа хийж илэрсэн зөрчлийг, ДХХ-ийн албан шаардлагаар арилгуулах арга хэмжээ авч ажиллах	2, 4-р сард	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Автын инженер, ХАБ-ын инженер Д. Равжих	Хийгдсэн
34	"Зөөврийн шатыг ашиглах, турших журам"-ын мөрдөлтөд хяналт тавих, батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах.	Тогтмол	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цех, хэсгийн дарга нар, цех хариуцсан ХАБ-ын инженерүүд	Хяналт тавьж ажиллаж байна.
Долоо. Цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдлын талаар					
35	Станцын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн газардуулгын хүрээний бүрэн бүрэн байдал, хэмжилт туршилтад хяналт тавих	Графикайн дагуу	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цахилгаан цехийн дарга, өндөр хүчдэлийн хэмжилтийн инженер, цех хариуцсан ХАБ-ын инженерүүд	Графикайн дагуу туршилт хийж, хэрэгжилтэнд хяналт тавьж байна.
36	Станцын аваарийн гэрэлтүүлгийн ажиллагааны байдалд хяналт тавьж ажиллах	Графикайн дагуу	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цахилгаан цехийн дарга, ашиглалтын инженерүүд, ХАБИ Жа.	Станцын бүрэн зогсолтын үед аваарийн гэрэлтүүлгийн АВР-н ажиллагааг шалгахад хяналт тавьж ажилласан.



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ДХХ-50-2022

Хувилбар 2

				Мөнх-Эрдэнэ	
37	Цахилгаан тоног төхөөрөмжийн нарийн төвөгтэй сэлгэн залгалтуудыг сэлгэн залгалтын хөтөлбөрөөр хийж байгаад хяналт тавих	Тогтмол	ХАБ хяналтын инженер С.Болормаа	Цахилгаан цехийн дарга, ашиглалтын инженер, ХАБИ Жа. Мөнх-Эрдэнэ	Нарийн төвөгтэй сэлгэн залгалтанд хяналт тавьж ажиллаж байна.
38	Цахилгааны хамгаалах, тусгаарлах багаж хэрэгслийн туршилт баталгаажилтад хяналт тавьж ажиллах	Графикийн дагуу	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Цахилгаан цехийн дарга, өндөр хүчдэлийн хэмжилтийн инженер, ХАБИ Жа. Мөнх-Эрдэнэ	Графикийн дагуу туршилт хийж, хэрэгжилтэнд хяналт тавьж байна
Найм. Химийн бодисын ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт, сав баглаа боодлын талаар					
39	Хүчлийн аж ахуйд демонтаж хийхэд хяналт тавих.	Тогтмол	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	ХАБ-ын инженер М.Нургуль	Хяналт тавьж ажилласан.
40	Химийн хортой бодисыг тээвэрлэх, ачих, буулгах үеийн аюулгүй ажиллагаа мөрдүүлэх, хадгалах, хамгаалах, агуулах, сав баглаа боодлын аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах.	Тогтмол	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	Хими цехийн дарга Ё.Цогтбаяр, ХАБ-ын инженер М.Нургуль	Хяналт тавьж ажиллаж байна.
41	Химийн хортой бодис байрлуулах зориулалтын тавцан, шошго хаяг, анхааруулах, сэрэмжлүүлэх плакат, самбар үзүүлэнг стандартын дагуу хийж байрлуулсан эсэхэд үзлэг шалгалт хийж ХАБЭА-н мөрдөлтөд хяналт тавих.	Тогтмол	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	ХАБ-ын инженер М.Нургуль	Стандартын дагуу хаяг шошго байршуулсан.



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ДХХ-50-2022

Хувилбар 2

42	Химийн хорт болон аюултай хортой харьцаж ажилтнуудыг сургалтад (бодис бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө гэх мэт) хамруулж, гарын үсэг зуруулсны дараа ажиллуулах ба сургалтад хамрагдаагүй ажилтныг химийн хортой бодистой харьцаж ажиллахыг хориглох, хяналт тавих	Тогтмол	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	ДХХ-ийн хими лабораторийн эрхлэгч Б.Нарангэрэл	Хяналт тавьж ажиллаж байна.
43	Химийн хорт болон аюултай бодист, хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулж, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсээр батлуулсан байна. Энэ журмын (3.1.1.3) заалтыг ДХХ-ийн химийн лаборатор, Хими цехэд шаардаж шинээр боловсруулан, батлагдсан төлөвлөгөөг ажлын байруудад байршуулах ажлыг зохион байгуулах.	Тогтмол	ХАБ хяналтын инженер С.Болормаа, Б.Наранцацрал	ХАБ-ын инженер М.Нургуль	Төлөвлөгөөг ажлын байранд байршуулсан.

ГҮЙЦЭТГЭЛ:

ХАБ ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

С.БОЛОРМАА



ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АШБ-ДХХ-195-2022

УГААНБААТАР ХОТ
Хувилбар 2

БАТЛАВ: ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨХК
Н.ЧИМЭДДОРЖ

УХМ00063 2546191
17022006

2024 ОНД ХАБЭА-Н ЧИГЛЭЛЭЭР ЯВУУЛАХ НИЙТ АЖИЛТНЫ СУРГАЛТЫН НЭГДСЭН ХУВААРЬ

2024.01.05

д/д	Сургалтын сэдэв / сарууд	Сургалтанд хамрагдах ажилтны тоо	1-р улирал			2-р улирал			3-р улирал			4-р улирал		
			I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Гадны байгууллагын сургалтууд														
1	Нийт ажилтны сургалт	100												
2	ХАБЭА-н мэргэшсэн ажилтны сургалт	10												
3	Зуух, даралтат савны бүрэн бүтэн байдал, ашиглалт, аюулгүй ажиллагаа, хяналт хариуцагчийн эрх олгох сургалт	130												
4	Өргөх зөөх механизмын бүрэн бүтэн байдал, хяналт хариуцагч, ачаа шилжүүлэх үеийн АА хариуцагчийн эрх олгох сургалт	66												
5	Эмнэлгийн анхан тусламж үзүүлэх сургалтанд хамрагдах, дадлага хийх	25												
6	Эрсдэлтэй ажлын байрны сургалт: Өндөрт ажил гүйцэтгэх	25												
7	ХАБЭА-н асуудал хариуцсан зөвлөлийн гишүүдийн сургалт	10												
Дотоод сургалтууд														
1	"ДЦС-3"ТӨХК-ийн ХЭМАБ-ын бодлого, зорилтыг танилцуулах	109												
2	Тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэл, тэдгээрийг зөв ашиглах	461												
3	Аюулгүй ажиллагааг хангах зохион байгуулалтын арга хэмжээнүүд	531												
4	Аюултай эрчим хүчийг хянах буюу түгжих, пайзлах ажиллагаа	433												
5	Шат тавцан бусад хэрэгсэл дээр өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагаа	261												
6	Хүнд хүчир зүйлийг өргөх тээвэрлэх	52												
7	Хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуй, сөрөг хүчин зүйлс, мэргэжлээс шалтгаалах өвчин, урьдчилан сэргийлэх	292												
8	Газар шорооны ажил хийх үеийн аюулгүй ажиллагаа	14												

д/д	Сургалтын сэдэв / сарууд	Сургалтанд хамрагдах ажилтны тоо	1-р улирал			2-р улирал			3-р улирал			4-р улирал		
			I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
9	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх тухай журам	14	Уурын хэсэг											
10	Цахилгаан, цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	153	ЦЦ						ДХХА					
11	ХАБ-ын хяналтын журам (шинэчилсэн хувилбар)	99	ЦЦ											
12	ХАБЭА-н тухай хууль, ажил хөдөлмөр эрхэлж буй иргэн, ажилтны эрх ба үүрэг	321	ДХХА,ЗЦ						ЦЦ					
13	Цахилгаан соронзон орны тухай, хүний эрүүл мэндэд нөөлөлөх нөлөөллийн талаар	109	ӨДТ, ДДТ			-?								
14	Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, Хувь хүний эрсдэлийн үнэлгээ хийж TAKE-5 хуудас бөглөх талаар	479	ХЦ,ЗЦ,ДХХА,ТДЦ,ӨДТ,ДДТ											
15	Эргэх механизмтай харьцаж ажиллах үеийн аюулгүй ажиллагаа	170	ТДЦ						ДХХА					
16	Даралтат савны турай ойлголт, даралтат сав шугам хоолойтой харьцаж ажиллах үеийн аюулгүй ажиллагаа	141	ДДЗ, ӨДЗ											
17	Хөдөлмөрийн тухай хууль	168	ЗЦ											
19	ХАБЭА-н эрүүл ахуйн зарчмууд	168	ЗЦ											
20	Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ	168	ЗЦ											
22	Харилцаа, хандлага	116	ТДЦ			-?								
23	Хязгаарлагдмал орчинд ажиллах	116	ТДЦ											
24	Гараар болон машин механизмаар ачаа зөөх, шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаа	116	ТДЦ											
25	Зөв зохистой хооллолт	116	ТДЦ											
26	Ажлын байрны эмх цэгц 5С	116	ТДЦ											
27	Шинээр ажилд орсон ажилтны сургалт	-	Тухай бүр											
28	Ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалт	-	Тухай бүр											

ХЯНАСАН:

ДХХ-Н ДАРГА

АХЛАХ ИНЖЕНЕР

ХУВААРЬ ГАРГАСАН:

ХАБ ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

Ж.МӨНХ-ЭРДЭНЭ

Н.БЯМБАДОРЖ

Б.НАРАНЦАЦРАЛ



"ДЦС-3" ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Н.ЧИМЭДДОРЖ

УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ДУЛААНЫ ГУРАВДУГААР
ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨХК
УЖМ0063 2546191
11162249-6

"ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
НИЙТ АЖИЛТНУУДАД ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ, ГАЛ ЭСЭРГҮҮЦЭХ
ДАСГАЛЫГ ЗОХИОН ЯВУУЛАХ 2024 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023.12.20

Улаанбаатар хот

д/д	Хичээл сургалтын сэдэв	Дадлага сургалтын сэдэв	Хариуцах албан тушаалтан	Сургалт явуулах хугацаа	Биелэлт
1	Гамшгийн тухай ойлголт, Газар хөдлөлтийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ,	Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах	Гал түймэртэй тэмцэх гэрээт хэсэг	1 дүгээр улирал	
2	Гамшгаас хамгаалах анхан шатны сургалт	Гадна болон дотор усан хангамж ашиглан гал түймэр унтраах	"ДЦС-3" ТӨХК, Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв Гал түймэртэй тэмцэх гэрээт хэсэг	2 дугаар улирал	
3	Гал түймрийн тухай ойлголт, Эрчим хүчний байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдал, Гал түймэр унтраах тоног төхөөрөмжийн ашиглалт, бэлэн байдлын хяналт, үйлчилгээ	Сэтгэл зурвас зүйн дах тоноглолыг ашиглан авхаалж самбаагаа сорих	Гал түймэртэй тэмцэх гэрээт хэсэг	3 дугаар улирал	
4	Гамшгаас хамгаалах, гал түймэр унтраах төлөвлөгөө боловсруулах аргачлал, Гал түймэр гарсан үед хүний амь нас, байгууллагын эд хөрөнгийг авран хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт / ИТА-н сургалт/	Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм нормативын эрх зүйн баримт бичгийн жигдрэлт	Гал түймэртэй тэмцэх гэрээт хэсэг	4 дүгээр улирал	

ТАНИЛЦСАН:
ҮЙЛДВЭРИЙН АЛБАНЫ ДАРГА

ЗАСВАР ХЯНАЛТЫН АЛБАНЫ ДАРГА

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:
ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ГЭРЭЭТ ХЭСГИЙН
ДАРГА, ХОШУУЧ

Л.БӨХБОЛД

Ц.БАТМАГНАЙ

Ж.МӨНХ-ЭРДЭНЭ

Ц.ИДЭРМӨРӨН



“ДЦС-3” ТӨХК-ИЙ ЗЦ-Н 2024 ОНЫ II УЛИРАЛД ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ГАЛ ЭСЭРГҮҮЦЭХ ДАСГАЛ, АВААРЬ БОЛОН ОСОЛ ЭСЭРГҮҮЦЭХ ДАСГАЛЫН СУРГАЛТ ХИЧЭЭЛИЙН ТАЙЛАН

2024-04-10

1. Галын хичээл, дасгал сургуулалтийг 2024 онд өгөх Галын дасгал сургуулилтын төлөвлөгөөний дагуу цехийн нийт ажилчид болон, ИТА нар оролцож 2024 оны 04 дүгээр сарын 10-ны 08 цаг 30 минутад эхлүүлэн хичээл сэдвийн дагуу хийсэн.
2. Галын дасгал сургуулилт, **Осол эсэргүүцэх сургалтыг** Засварын цехийн ЦХЗБ-9, ТТЗБ-17, ЗЭМЗБ-9, ЗТСЗБ-15 хүн, ЗХГХАЗБ-16, ӨДЗБ-13 хүн, ТХГХАЗБ-20, ТЭМЗБ-17, ГХТЗБ-9, ИТА-16 нийт 141 ИТА, ажилтан оролцсон.



3. Гал болон аваарь эсэргүүцэх сургалтаар

Сэдэв: “Гамшгийн аюул”-ын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах


- Гамшгийн тухай ойлголт, гамшгийн төрөл
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, газар хөдлөлтийн тухай ойлголт
- Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээ

сэдвүүдээр ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ГЭРЭЭТ ХЭСГИЙН ДАРГА, ХОШУУЧ Ц.ИДЭРМӨРӨН хичээл оров.



4. Осол эсэргүүцэх сургалтаар

- ❖ Хийгээр хордох үзүүлэх ЭАТ
 - ❖ Аммиак болон химийн бодисуудад хордсон үед үзүүлэх ЭАТ
 - ❖ Наранд цохиулсан болон яс хугарсан үед ЭАТ
- сэдвүүдээр СТАНЦЫН ИХ ЭМЧ Г.ОЮУНБОЛД хичээл оров.



5. Гал түймэртэй холбоотой стандарт болон түүнийг хэрхэн мөрдөх, галын хортой хэрхэн ажиллах, галын шлангаар гал гарах үед хэрхэн ажиллах талаар шинээр засварчин болсон засварчдад зааварчилгаа өгөн дадлага сургуулилт хийгдсэн.





ДУЛААНЫ III ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/193

Улаанбаатар хот

Комисс томилох тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ДЦС-3” ТӨХК-д гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судалж акт тогтоох үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Ерөнхий инженер
Гишүүд:	Дотоод хяналтын хэлтсийн дарга Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга Тухайн алба, хэлтэс, цех, хэсгийн дарга Тухайн алба, хэлтэс, цех, хэсгийн ахлах болон ашиглалтын инженер Хүний нөөцийн мэргэжилтэн Их эмч Эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан Үйлдвэрчний эвлэлийн хорооны хоёр тэргүүлэгч
Нарийн бичгийн дарга:	Дотоод хяналтын хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал хяналтын инженер

2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судлан тогтоох (Комиссын дарга, Ерөнхий инженер)-т ДААЛГАХ нь:

- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судлахдаа холбогдох мэргэжлийн инженер техникийн ажилтнуудыг татан оролцуулж дүгнэлт гаргах.
- Засгийн газраас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхдээ шалтгааныг нь нарийвчлан тогтоож, цаашид урьдчилан сэргийлэх ажил төлөвлөн гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах.

1701012805

2.

3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж, Захирлын зөвлөлийн хуралд мэдээлж ажиллахыг (Дотоод хяналтын хэлтсийн дарга)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Гүйцэтгэх захирлын А/75 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Л.ЭРХБААТАР



ДУЛААНЫ III ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/184

Улаанбаатар хот

“ДЦС-3” ТӨХК-ИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО-Г БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.6, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 28.1.6, Хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO 45001:2018 стандартын хүрээнд “ДЦС-3” ТӨХК-ийн Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлого”-ыг нэгдүгээр хавсралтаар, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоонд байгууллагын бүх түвшний ажилтнуудын холбогдох үүрэгт хамаарах үүрэг, хариуцлагыг тохоон хуваарилсан үүрэг хариуцлагын матрицийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Дотоод хяналтын хэлтсийн дарга / Ж.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Л.ЭРХБААТАР



17010125-1



“Дулааны цахилгаан станц-3” ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2024 оны 08 дугаар
сарын 09 ны өдрийн А/184 дугаар
тушаалын хавсралт




“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК нь үйл ажиллагаандаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомж, стандартыг мөрдөж, удирдлагын багийн манлайлал, ажилтны оролцоонд суурилсан аюулгүй байдлын соёлыг бүрдүүлж, эрсдэлийн менежментийг цогц байдлаар хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулна.


MNS ISO 45001:2018 СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАМРАХ ХҮРЭЭ

“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ийн цахилгаан, дулаан үйлдвэрлэх, түгээх үндсэн үйл явц болон нийт ажилтнууд, хамтрагч, түншлэгч байгууллагуудын хэрэгцээ шаардлага нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хамрах хүрээнд багтана.

“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ҮЙЛ ЯВЦ



Дулааны цахилгаан станц-3 ТӨХК-ийн
 Гүйцэтгэх захирлын 2024 оны 08 дугаар
 сарын 09 -ны өдрийн А/184 дугаар
 тушаалын хавсралт



**“ДЦС-3” ТӨХК-ИЙН АЖИЛТНУУДЫН ХЭМАБ-ЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНД ХАМААРАХ
 ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГЫН МАТРИЦ**

R - Responsible /Чиг үүргийн хүрээнд эцсийн үр дүнг хариуцагч/	C - Consulted /Дэмжлэг үзүүлэн оролцогч/	A - Accountable /Хариуцан гүйцэтгэгч/	I - Informed /Үр дүнгийн мэдээлэл авсан/
--	--	---	--

№	ХЭМАБ-ын үндсэн үйл явцууд / албан тушаал	Гүйцэтгэх захирал	Ерөнхий инженер	Дотоод хяналтын хэлтсийн дарга	Алба, хэлтэс, хэсгийн дарга нар	Цехийн дарга	ҮЭХ-н дарга	ХАБ хяналтын инженер	ХАБ-ын инженер	Алба, хэлтэс, цех, хэсгийн инженер/ мастер	Шуурхай ажиллагааны удирдлага /ДИС., э/дарга/	Ажилтан
1	ХЭМАБ-ын бодлого	R	C	R	C	C	I	A	A	C	I	I
2	ХЭМАБ-ын зорилт	R	C	R	C	C	I	A	A	C	I	I
3	ХЭМАБ-ын төлөвлөгөө	R	C	R	C	R	I	A	C	A	I	I
4	Аюулыг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээ	R	C	R	R	R	I	C	A	A	A	A
5	Аюултай тохиолдлыг судлах	R	C	R	C	C	A	A	A	C	C	C
6	Үл тохирлыг залруулах арга хэмжээ	R	C	R	R	R	I	A	C	A	C	I
7	Эрсдэлийг бууруулах	C	C	C	R	R	C	C	A	A	A	A
8	ХЭМАБ-ын үйл ажиллагааны хяналт	R	C	R	R	R	C	A	A	A	A	C
9	ХЭМАБ-ын ур чадварыг тодорхойлох, үнэлэх	R	C	C	C	R	C	A	A	A	C	I
10	ХЭМАБ-ын дотоод аудит	C	C	R	I	I	C	A	A	C	I	I
11	Удирдлагын дүн шинжилгээ	R	R	R	R	R	C	A	C	A	I	I
12	Хэмжилт мониторинг	C	C	R	I	I	I	I	C	I	I	I



ДУЛААНЫ Ш ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/193

Улаанбаатар хот

Комисс томилох тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "ДЦС-3" ТӨХК-д гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судалж акт тогтоох үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

Ерөнхий инженер

Гишүүд:

Дотоод хяналтын хэлтсийн дарга
Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
Тухайн алба, хэлтэс, цех, хэсгийн дарга
Тухайн алба, хэлтэс, цех, хэсгийн ахлах
болон ашиглалтын инженер
Хүний нөөцийн мэргэжилтэн
Их эмч
Эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан
Үйлдвэрчний эвлэлийн хорооны хоёр
тэргүүлэгч

Нарийн бичгийн дарга:

Дотоод хяналтын хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал хяналтын инженер

2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судлан тогтоох (Комиссын дарга, Ерөнхий инженер)-т ДААЛГАХ нь:

- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгааныг судлахдаа холбогдох мэргэжлийн инженер техникийн ажилтнуудыг татан оролцуулж дүгнэлт гаргах.
- Засгийн газраас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхдээ шалтгааныг нь нарийвчлан тогтоож, цаашид урьдчилан сэргийлэх ажил төлөвлөн гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах.

1701012805

2.

3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж, Захирлын зөвлөлийн хуралд мэдээлж ажиллахыг (Дотоод хяналтын хэлтсийн дарга)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Гүйцэтгэх захирлын А/75 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Л.ЭРХБААТАР



Л.ЭРХБААТАР



М.ТЭМҮҮЛЭН

**ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС ХУДАЛДАХ,
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

2024 оны 04-р сарын 16-ны өдөр

Дугаар 1-3-213/24

Улаанбаатар хот

Нэг талаас “ДЦС-3” ТӨХК-ийг төлөөлөн Ерөнхий инженер Н.Чимэддорж (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас “МТӨТ” ХХК-ийг төлөөлөн Захирал М.Тэмүүлэн (цаашид “Нийлүүлэгч” гэх) дараах нөхцөл, зүйлийг харилцан тохиролцож Иргэний хуулийн 243-261 дэх заалт, Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу ДЦСЗ/20240102059 дугаартай тендерт Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1. Захиалагч Хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авах, (ДЦСЗ/20240102059) (цаашид “бараа” гэх)-г 300,777,785.00 (гурван зуун сая долоон зуун далан долоон мянга долоон зуун наян таван) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
2. Гэрээний нийт дүн: 300,777,785.00 (гурван зуун сая долоон зуун далан долоон мянга долоон зуун наян таван) төгрөг байна. Урьдчилгаа төлбөр олгохгүй бөгөөд захиалагч барааг хүлээн авсны дараа нийлүүлэгчийн ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн 30 хоногийн дотор шилжүүлнэ.
3. Нийлүүлэгч барааг Захиалагчийн хашаа, агуулахад ирсний дараа холбогдох инженер техникийн ажилтнууд техникийн тодорхойлолтод заасан стандарт, шаардлагад нийцсэн эсэхийг шалгаж акт үйлдэн холбогдох баримт материалыг хамт хүлээн авна.
4. Нийлүүлэгч нь Хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авах, (ДЦСЗ/20240102059)-г гэрээ байгуулсан өдрөөс хойш 2025 оны 03-р сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд, захиалга өгсөн өдрөөс хойш 7 хоногийн дотор багтаан нийлүүлж, актаар хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 5.2 Нийлүүлэгч тендер илгээсэн үнийн санал;
 - 5.3 Гэрээний тусгай нөхцөл;
 - 5.4 Гэрээний ерөнхий нөхцөл;

БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН ХҮЛЭЭЛЦСЭН АЖЛЫН АКТ

2024.09.20

“ДЦС-3” ТӨХК болон “МТОТ” ХХК-ийн байгуулсан “Хөдөлмөр хамгааллын хувцас худалдах, худалдан авах гэрээ” № 1-3-213/24 тоот гэрээний дагуу ажлын цамц /нимгэн/ 288 ш хүлээлцэв.

Д/д	Бүтээгдэхүүний нэр төрөл	Тоо хэмжээ	Размер
1.	Ажлын цамц /нимгэн/	288 ш	Эрэгтэй 42 раз -1, 48 раз -70, 50 раз -85, 52 раз -30, 54 раз -40, 56 раз -10, 58 раз -10, 64 раз-2 эрэгтэй нийт 248ш Эмэгтэй 38 раз-1, 40 раз-4, 42 раз-15, 44 раз -5, 46 раз -10, 48 раз-5, эмэгтэй нийт 40ш Нийт 288 ш

Хүлээн авсан:

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны инженер
С. Болормаа _____

Нярав
Д.Нэргүй _____



“МТОТ” ХХК гүйцэтгэх захирал
М.Отгонтуяа _____



Л.ЭРХБААТАР



Ш.БАТСАЙХАН

АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙТЭЛ, ШАВЬЖ МЭРЭГЧИЙН УСТГАЛ ХИЙХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2024 оны 02 -р сарын 06 ны

№ 1-6-93/24

Улаанбаатар хот

Нэг талаас “Дулааны Гуравдугаар Цахилгаан станц” ТӨХК /цаашид “Үйлчлүүлэгч” гэх/-ыг төлөөлж Дотоод хяналтын хэлтсийн дарга Ж.Мөнх-Эрдэнэ, нөгөө талаас “ЦАЦУ” ХХК /цаашид “Үйлчлэгч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Батсайхан нар Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Удирдлагын шийдвэрийг үндэслэн эрх тэгш харилцан ашигтай байх зарчмыг баримтлан харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7, 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ариутгал халдваргүйтэл, мэрэгч, шавьж, зөгий устгалтын үйлчилгээг хийлгэж халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, хортон шавьж мэрэгчийн тархалтыг багасгаж, үйлчлүүлэгчдийн ая тухтай эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2. Гэрээ нь хоёр тал гарын үсэг зурж, баталгаажсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

Хоёр. Гэрээний үйлчлэх хугацаа, төлбөр тооцоо

- 2.1. Гэрээний үйлчлэх хугацаа 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хүртэл мөрдөгдөнө.
- 2.2. Үйлчлүүлэгч байгууллага нь 3800.1 м² талбайд ариутгал, шавьж устгалыг жилд 4 удаа, 2935 м² талбайд мэрэгч устгалыг жилд 4 удаа, бусад устгал, ариутгалыг хавсралтаар зөвшөөрөгдсөн хор бодисоор хийлгэнэ./Талбайн хэмжээг хавсралт №1, 2 –д заасан/
- 2.3. Гэрээний нийт хөлс 16,943,712.00 (арван зургаан сая есөн зуун дөчин гурван мянга долоон зуун арван хоёр) төгрөг байна. Үйлчилгээний хөлсөнд НӨАТ болон бусад татвар орсон болно.

“ДЦС-3” ТӨХК-ИЙН ХАМТ ОЛОН “ХҮЙТЭН ӨВЛИЙГ ХАЛУУН СЭТГЭЛЭЭР-2” МАЛЧДАД ТУСЛАХ ХАНДИВЫН АЯНГ АМЖИЛТТАЙ ӨРНҮҮЛЛЭЭ

2024.03.04

Монгол Улсад энэ жил олон жилийн дундажаас илүү их хур тунадас, цас орж улсын хэмжээнд зудын нөхцөл байдал үүсч олон тооны мал хорогдож байгаа энэ цаг үед “ДЦС-3” ТӨХК-ийн хамт олон өвөлжилт, хаваржилт хүндэрсэн аймаг орон нутгийн малчдад тусламж үзүүлэх **“ХҮЙТЭН ӨВЛИЙГ ХАЛУУН СЭТГЭЛЭЭР-2”** Хандивын аянг 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдөр хүртэл амжилттай зохион байгууллаа.

Зуданд нэгвэгдэж буй малчдад туслах хандивын аянд станцын удирдлага, ерөнхий инженер, бүх алба, хэлтэс, цех, хэсэг, нэгжийн ажилтнууд мөн станцын ахмадууд, цайны газар, харуулын хэсгийн бие бүрэлдэхүүн гээд өргөн хүрээтэй оролцлоо. Тус хандивт цугласан мөнгө, бараа материалыг Онцгой байдлын ерөнхий газрын шуурхай (Улсын онцгой комисс) штаб-д 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдөр албан ёсоор компанийн Гүйцэтгэх захирал Л.ЭРХБААТАР хүлээлгэн өгч малчдад туслах сайн дурын хандивын аянг өндөрлүүллээ.

Малчдад туслах аянд нэгдсэн хамт олондоо маш их баярлалаа та бүхний үйлс бүхэн бүтэмжтэй байх болтугай.









**"ДЦС-3" ТӨХК-ИЙН МАЛЧДАД ТУСЛАХ АЯНЫ ХАНДИВЫН ДАНСАНД ЦУГЛАСАН
МӨНГӨН ДҮН, БҮРТГЭЛ**

2024.03.04

№	Удирдлага, алба, хэлтэс, цех	Овог нэр	Мөнгөн дүн	Тайлбар
1	Гүйцэтгэх захирал	Л.Эрхбаатар	500,000	Бэлэн
2	Ерөнхий инженер	Н.Чимэддорж	300,000	Бэлэн
3	Захиргаа хүний нөөцийн алба		260,000	Бэлэн
4	Техникийн бодлогын хэлтэс		260,000	шилжүүлэг
5	Санхүү бүртгэлийн хэлтэс		300,000	шилжүүлэг
6	Хангамжийн хэлтэс		500,000	Бэлэн
7	Дотоод хяналтын хэлтэс, Дотоод аудитор		500,000	шилжүүлэг
8	Төлөвлөлт эдийн засгийн хэлтэс		140,000	шилжүүлэг
9	Горим тооцооны хэлтэс		100,000	шилжүүлэг
10	Үйлчилгээ аж ахуйн хэсэг, Эмнэлэг		400,000	Бэлэн
11	Уурын хэсэг		150,000	шилжүүлэг
12	Авто аж ахуйн хэсэг		170,000	шилжүүлэг
13	Үйлдвэрчний эвлэлийн хороон дарга		50,000	Бэлэн
14	Түлш дамжуулах цех		1,270,000	шилжүүлэг
15	Дунд даралтын зуухан цех		600,000	Бэлэн
16	Өндөр даралтын зуухан цех		1,050,000	шилжүүлэг
17	Дунд даралтын турбин цех		500,000	шилжүүлэг
18	Өндөр даралтын турбин цех		500,000	шилжүүлэг
19	Цахилгаан цех		780,000	Бэлэн
20	Механик цех		550,000	Бэлэн
21	Хими цех		300,000	Бэлэн
22	"Батнансал" ХХК	Түрээслэгч	300,000	шилжүүлэг
23	Хими цехийн инженер	С.Наранцацрал	10,000	шилжүүлэг
24	ҮААХэсгийн ажилтан	Л.Намжилмаа	20,000	шилжүүлэг
25	ӨДТ Ахмад ажилтан	Б.Чулуунбат	30,000	шилжүүлэг
26	ЗЦ- Гал химийн бригадын өндөр настан	Б.Батхүү	30,000	шилжүүлэг
27	ДДТ Ахмад ажилтан	Ш.Энхтуяа	20,000	шилжүүлэг
28	Санхүү бүртгэдлийн хэлтсийн нягтлан	П.Саранханд	20,000	шилжүүлэг
29	ӨДЗЦех зуухны машинч	Б.Буяндалай	20,000	шилжүүлэг
30	Цахилгаан цех Ахмад ажилтан	Д.Оюунчимэг	20,000	шилжүүлэг
31	ДДЗЦех ахмад ажилтан	О.Пүрэвдагва	20,000	шилжүүлэг
32	Механик цех Ахмад ажилтан	Д.Эрдэнэбилэг	20,000	шилжүүлэг
33	Ахмад ажилтан	Д.Золжаргал	20,000	шилжүүлэг
34	Цахилгаан цех Ахмад ажилтан	н.Лхагвасуурь	30,000	шилжүүлэг
35	Цахилгаан цех	Г.Энэрэл	20,000	шилжүүлэг
36	Өндөр настан	Г.Ганбаатар	20,000	шилжүүлэг
			9,780,000	

**"ДЦС-3" ТӨХК-ИЙН МАЛЧДАД ТУСЛАХ АЯНД ЦУГЛАСАН БАРАА, МАТЕРИАЛЫН
ТОО ХЭМЖЭЭ, БҮРТГЭЛ**

2024.03.04

д/д	Нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	Хивэг	Шуудай	81	25 кг
2	Гурил	Уут	31	5 кг
3	Гурил	Уут	1	1 кг
4	Будаа	Уут	1	3 кг
5	Будаа	Уут	8	5 кг
6	Будаа	Шуудай	1	30 кг
7	Будаа	Уут	1	3 кг
8	Будаа	Уут	1	4 кг
9	Шар будаа	Уут	1	1 кг
10	Давс	Уут	12	1 кг
11	ОО-н цаас	ш	12	
12	Шүдэнз	Толгой	64	10 ш
13	Лаа	боодол	19	5 ш
14	Газ	ш	4	Ахуйн
15	Витамин С	Хайрцаг	4	10 ш
16	Асаагуур	ш	1	Ахуйн
17	Гоймон	Уут	1	3 кг
18	Гоймон	Уут	54	300 гр
19	Гоймон	Уут	1	6 кг
20	Ургамалын тос	ш	1	1 л
21	Оймс	ш	5	хос
22	Дулаан хувцас	ш	15	Хуучин
23	Куртка	ш	3	
24	Нэмнээ (том)	ш	36	Хими, Цахилгаан цехүүд
25	Нэмнээ (жижиг)	ш	30	Цахилгаан, Хими цехүүд



**ДУЛААНЫ Ш ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

17070 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө, Утас/Факс: (976-11) 34-30-24,
Цахим шуудан: ps3@tes3.energy.mn
Цахим хуудас: www.tes3.energy.mn

2024.03.04 № 1/356
танай _____-ны № _____-т

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗАРТ**

**Малчдад туслах хандив хүргүүлэх
тухай**

Манай станц нь Монгол Улсын төвийн эрчим хүчний системийн цахилгаан хэрэглээний 16 %, Улаанбаатар хотын дулаан хангамжийн 32 %, үйлдвэрүүдийн технологийн уурын хэрэглээний 47 %-ийг дангаараа ханган ажилладаг улсын онц чухал объект юм.

Монгол Улсад энэ жил олон жилийн дундажаас илүү их хур тунадас, цас орж улсын хэмжээнд зудын нөхцөл байдал үүсч олон тооны мал хорогдож байгаа энэ цаг үед "ДЦС-3" ТӨХК-ийн хамт олон өвөлжилт, хаваржилт хүндэрсэн аймаг орон нутгийн малчдад тусламж үзүүлэх "ХҮЙТЭН ӨВЛИЙГ ХАЛУУН СЭТГЭЛЭЭР-2" сайн дурын хандивын аянг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр хүртэл өрнүүлж бараа, бүтээгдэхүүн, мөнгөн тусламж цуглууллаа.

Иймд тус аянд цугласан бараа, бүтээгдэхүүнийг орон нутгийн малчдад хүргүүлэхээр танай байгууллагын шуурхай штаб-д хүлээлгэн өгч байна.

Жич: "Хүйтэн өвлийг халуун сэтгэлээр-2" аянд цугласан бараа бүтээгдэхүүний бүртгэлийг хавсаргав.

Хавсралт 1 хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Л.ЭРХБААТАР



"ДЦС-3" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2024 оны 03 дугаар сарын 04-ны
өдрийн 1/356 тоот албан бичгийн хавсралт

**"ДЦС-3" ТӨХК-ИЙН ХАМТ ОЛНООС ЗУДАНД НЭРВЭГДСЭН МАЛЧДАД ӨГЧ БҮЙ
ХАНДИВЫН БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НЭГДСЭН БҮРТГЭЛ**

д/д	Нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдан авалт	Тайлбар
1	Хивэг	Шуудай	81		25 кг
2	Хорголжин	Шуудай	62	2,000,000	40 кг
3	Тэжээл, уураг	Шуудай	116	4,999,600	30 кг
4	Төл малын уураг, сүү	Шуудай	12	1,440,000	10 кг
5	Гурил	Уут	31		5 кг
6	Гурил	Уут	1		1 кг
7	Будаа	Уут	1		3 кг
8	Будаа	Уут	8		5 кг
9	Будаа	Шуудай	1		30 кг
10	Будаа	Уут	1		3 кг
11	Будаа	Уут	1		4 кг
12	Шар будаа	Уут	1		1 кг
13	Давс	Уут	12		1 кг
14	ОО-н цаас	ш	12		
15	Шүдэнз	Толгой	64		10 ш
16	Лаа	боодол	19		5 ш
17	Газ	ш	4		Ахуйн
18	Витамин С	Хайрцаг	4		10 ш
19	Асаагуур	ш	1		Ахуйн
20	Гоймон	Уут	1		3 кг
21	Гоймон	Уут	54		300 гр
22	Гоймон	Уут	1		6 кг
23	Ургамалын тос	ш	1		
24	Оймс	ш	5		
25	Дулаан хувцас	ш	15		Хуучин
26	Куртка	ш	3		
27	Нэмнээ (том)	ш	36		
28	Нэмнээ (жижиг)	ш	30		

Хандивт цугласан мөнгөний зарцуулалт:

д/д	Нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Мөнгөн дүн	Тайлбар
1	Улсын онцгой комиссын данс	төгрөг		1,340,400	Шилжүүлсэн
2	Хорголжин тэжээл	Шуудай	62	2,000,000	Худ-н авалт
3	Малын тэжээл, уураг	Шуудай	116	4,999,600	Худ-н авалт
4	Төл малын уураг, сүү	Шуудай	12	1,440,000	Худ-н авалт
	Нийт			9,780,000	Үлдэгдэл 0 т

Огноо/Date: 2024.03.04 17:45:07

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 38023434

Системийн огноо/System Date: 2024.03.04 17:45:07

Дт/From	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5033418140	Г*****Р АНАРЗУЛ	1,340,400.00 MNT	1.00

/ Нэг сая гурван зуун дөчин мянга дөрвөн зуун төгрөг /

Кт/To	Банкны дугаар/Branch No 05	Банкны нэр/Bank Name Khan Bank - Хаан банк	Дүн/Amount	Ханш/Rate
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 5263315732	Нэр/Name ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР	1,340,400.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ДЦС-3 ТӨХК-н 2024.03.04 1/356 тоот 99001531

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Cap/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

“ДЦС-3” ТӨХК ЭЗЭМШИЛ ГАЗРАА (55 га)-аар НЭМЭГДҮҮЛЛЭЭ

2024.09.19

Манай станц нь анх байгуулагдсан цагаас хойш зуухны шаталтаас ялгаран гарсан үнсийг тусгай зориулалтын санд хуримтлуулан хадгалж байна. Тус станц нь **1991** онд үнс хадгалах сангийн зориулалтаар **33** га газрыг эзэмшилдээ авч байсан бөгөөд 2021 онд сүүлийн 9.3 га газарт үнс хадгалах сан №6-г ашиглалтанд оруулан ашиглаж байна.

Өнөөгийн үнс хадгалах сангуудын орчимд дахин олгох газар байхгүй, усны тухай хуулиар ундны усны эрүүл ахуйн хамгаалалтын зурваст орсон байдал, одоо ашиглаж байгаа үнс хадгалах сан 6-г дүүрэхээс өмнө дараагийн үнс хадгалах санг бэлдэх, эрчим хүчний хэрэглээний өсөлтөөс хамаарсан нүүрсний хэрэглээ тогтмол өсч байгаа зэрэг хүндрэлтэй асуудлуудтай тулгарч байна.

Дээрх станцын тасралтгүй үйл ажиллагаанд шууд нөлөөлөх тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр Нийслэлийн холбогдох байгууллагуудтай уулзалтууд зохион байгуулсны үр дүнд 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч **Х.Нямбаатар А/635** тоот захирамж гарган “ДЦС-3” ТӨХК-ийн эзэмшилд шинээр үнс хадгалах сангийн зориулалтаар **55 га** газар олгохоор шийдвэрлэсэн.

Тус захирамжийн хүрээнд Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны төлөөлөл 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр станцын үйл ажиллагаатай танилцан шинээр эзэмшиж буй газрын гэрчилгээг Гүйцэтгэх захирал Л.Эрхбаатарт гардуулан өглөө. Дашрамд дурдахад Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас сүүлийн жилүүдэд үйлчилгээгээ сайжруулах талаар хэрэгжүүлсэн ажлын үр дүнд богино хугацаанд олон нийтэд цахимаар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэнд талархал илэрхийлье.

